- Хуурамч бүтээгдэхүүний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү сэрэмжлүүлгийн хавсралтаас харна уу.

Эрсдэл

Энэхүү хуурамч бүтээгдэхүүнд мэдээлээгүй нитазены нэгдлүүдийг агуулсан болох нь тогтоогдсон ба түүнийг бага тунгаар хэрэглэхэд ч ноцтой гаж нөлөө үзүүлэх магадлал өндөр байдаг.

Нитазен нь бусад опийн бүлэгтэй төстэй нөлөө үзүүлдэг бөгөөд тун хэтэрснээс үхэлд хүргэх эрсдэлтэй.

Нитазены деривативыг хэрэглэсэнтэй холбоотой нас баралтын хэдэ хэдэн тохиолдол гарч байсан. Тэдгээрийг согтууруулах ундаа эсвэл бензодиапезиний бүлгийн эмтэй хамт хэрэглэх нь маш аюултай бөгөөд амьсгалын замын дутагдалд хүргэх, цусны даралт бууруулахаас гадна цаашилбал кома, үхэлд хүргэдэг.

Хуурамч ОХУСОНТИН-ийг Польш, Швейцарь, Швед, Ирландаас ДЭМБ-д урьд нь мэдээлж байсан.

Эмнэлгийн мэргэжилтнүүд, Эмийн зохицуулалтын байгууллагууд, олон нийтэд өгөх зөвлөгөө

Эмнэлгийн мэргэжилтнүүд аливаа гаж нөлөө, эмчилгээ үр дүн муутай байх, хуурамч хэмээн сэжиглэсэн тохиолдлын талаар Эмийн зохицуулалтын байгууллагад мэдээлэх шаардлагатай. ДЭМБ эдгээр хуурамч бүтээгдэхүүнд өртөж болзошгүй улс орон, бүс нутгуудын нийлүүлэлтийн сүлжээнд хяналт, шалгалтыг нэмэгдүүлэхийг зөвлөж байна.

Хэрэв Оксиконтинийг хэтрүүлэн хэрэглэсэн гэж сэжиглэж байгаа бол (ялангуяа албан бус зах зээл дээр худалдаж авсан бүтээгдэхүүнээс), нитазены хордлого байж болзошгүйг анхаарах хэрэгтэй.

ДЭМБ эдгээр бүтээгдэхүүнийг хэрэглэхгүй байхыг зөвлөж байна. Энэхүү хуурамч бүтээгдэхүүн илэрсэн тохиолдолд эрх бүхий байгууллагууд ДЭМБ-д яаралтай мэдэгдэх шаардлагатай.

Хэрвээ та болон таны таньдаг хэн нэгэн уг бүтээгдэхүүнийг хэрэглэсэн буюу хэрэглэсэн байж магадгүй, эсвэл хэрэглэснээр урьдчилан таамаглаагүй гаж нөлөө илэрсэн бол эмнэлгийн мэргэжилтэнд хандахыг зөвлөж байна. Бүх бүтээгдэхүүнийг эрх бүхий/зөвшөөрөлтэй ханган нийлүүлэгчдээс авах ёстой.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ №01/2025

Бүтээгдэхүүний нэр	OxyContin 80mg
Үйлдвэрлэгч	Mundipharma A/S
Цувралын дугаар	262174
Хүчинтэй хугацаа	12/2025
Илэрсэн улс	Швейцари
Илэрсэн байдал	

СЭРЭМЖЛҮҮЛЭГ №02/2025

Төв Африкийн Бүгд Найрамдах Улс болон Камерун Улсад дөрвөн цувралын хуурамч HEALMOXY 500мг (Амоксициллин) капсултай эм илэрсэн талаар 2025 оны 03 дугаар сард ДЭМБ-д мэдээлсэн.

Жинхэнэ HEALMOXY капсултай эмийн үндсэн үйлчлэгч бодис нь Амоксициллин бөгөөд дунд чихний үрэвсэл, уушгины үрэвсэл, арьсны үрэвсэл, амны хөндийн үрэвсэл, шээсний замын халдвар зэрэг олон төрлийн нянгийн гаралтай халдварын үед хэрэглэдэг.

Энэхүү хуурамч бүтээгдэхүүнийг хэрхэн таних вэ?

Энэ бүтээгдэхүүний гарал үүсэл, найрлага, эх сурвалжийг санаатайгаар буруу мэдээлсэн тул хуурамч бүтээгдэхүүн гэж тогтоосон.

- Хуурамч HEALMOXY бүтээгдэхүүний дээжинд хийсэн шинжилгээгээр идэвхтэй бодис буюу амоксициллин агуулагдаагүй болохыг тогтоосон.
- Хуурамч бүтээгдэхүүний хоёр цувралын үйлдвэрлэсэн болон хүчинтэй хугацааны бичиглэлийн формат нь тохирохгүй байсан.

Эдгээр хуурамч бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн огноо нь 8 оронтой тоогоор өдөр/сар/жил (10/01/2027) гэсэн хэлбэрээр бичигдсэн.

Эрсдэл

Эдгээр хуурамч бүтээгдэхүүнүүд нь аюултай бөгөөд ялангуяа хүнд халдвартай эсвэл эмзэг бүлгийн хүмүүсийн эрүүл мэндэд ихээхэн эрсдэл учруулж болзошгүй. Хуурамч HEALMOXY (Амоксициллин) капсултай бүтээгдэхүүн нь үр нөлөөгүй бөгөөд нянгийн гаралтай халдварт хэрэглэж болохгүй.

Амоксициллин нь нян устгах эсвэл нянгийн өсөлтийг саатуулдаг. Эмийн үндсэн үйлчлэгч бодис байхгүй эдгээр бүтээгдэхүүн нь нянгийн гаралтай халдварыг эмчлэхэд үр нөлөөгүй бөгөөд халдварыг улам даамжруулах эсвэл тархахад хүргэнэ. Хуурамч HEALMOXY эмийг илрүүлэх болон устгах нь эмчлүүлэгчдэд сөрөг үр дагавар гарахаас сэргийлнэ.

Эмнэлгийн мэргэжилтнүүд, Эмийн зохицуулалтын байгууллагууд, олон нийтэд өгөх зөвлөгөө

Эмнэлгийн мэргэжилтнүүд аливаа гаж нөлөө илрэх, эмчилгээ үр дүн муутай байх, хуурамч гэж сэжиглэсэн тохиолдлын талаар Эмийн зохицуулалтын байгууллагад мэдээлэх ёстой. ДЭМБ эдгээр хуурамч бүтээгдэхүүнд өртөж болзошгүй улс орон, бүс нутгуудын нийлүүлэлтийн сүлжээнд хяналт, шалгалтыг нэмэгдүүлэхийг зөвлөж байна. Мөн албан бус/зохицуулалтгүй зах зээлд тавих хяналтыг нэмэгдүүлэхийг зөвлөж байна.

Эмийн зохицуулалтын байгууллага/эрүүл мэндийн байгууллага/хууль сахиулах байгууллагууд тухайн улсад хуурамч бүтээгдэхүүн илэрсэн тохиолдолд

ДЭМБ-д нэн даруй мэдэгдэхийг зөвлөж байна.

Хэрэв танд эдгээр бүтээгдэхүүний аль нэг нь байгаа бол хэрэглэхгүй байхыг ДЭМБ зөвлөж байна.




Хэрвээ та болон таны таньдаг хэн нэгэн уг бүтээгдэхүүнийг хэрэглэсэн буюу хэрэглэсэн байж магадгүй, эсвэл хэрэглэснээр урьдчилан таамаглаагүй гаж нөлөө илэрсэн бол эмнэлгийн мэргэжилтэнд хандахыг зөвлөж байна.



Бүх эмнэлгийн бүтээгдэхүүнийг тусгай зөвшөөрөлтэй ханган нийлүүлэгчдээс авах ёстой. Хэрэв танд эдгээр хуурамч бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн талаар мэдээлэл байвал ДЭМБ-тай rapidalert@who.int хаягаар холбогдоно уу.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ №02/2025

Бүтээгдэхүүний нэр	HEALMOXY Capsules 500mg		
Үйлдвэрлэгч	MAXHEAL PHARMACEUTICALS (India) Limited		
Илэрсэн улс	Камерун		
Цувралын дугаар	023011	023011	H02605
Хүчинтэй хугацаа	18/07/2025	10/01/2027	02/27



Илэрсэн байдал





Бүтээгдэхүүний нэр	HEALMOXY Capsules 500mg		
Үйлдвэрлэгч	MAXHEAL PHARMACEUTICALS (India) Limited		
Илэрсэн улс	Central African Republic		
Цувралын дугаар	H026051		
Хүчинтэй хугацаа	01/26		

Илэрсэн байдал



СЭРЭМЖЛҮҮЛЭГ №03/2025

Исламын Бүгд Найрамдах Иран болон Бүгд Найрамдах Турк Улсад гурван цувралын хуурамч Имфинзи худалдааны нэртэй (Дурвалумаб) 500мг/10мл тарилгын уусмал илэрсэн талаар 2025 оны 03 дугаар сард ДЭМБ-д мэдээлсэн.

ДЭМБ өмнө нь Бүгд Найрамдах Армен Улс, Бүгд Найрамдах Ливан Улс, Бүгд Найрамдах Турк Улсад илэрсэн хуурамч Имфинзи худалдааны нэртэй (Дурвалумаб) 500мг/10мл тарилгын уусмалын талаар сэрэмжлүүлэг №5/2024 гаргасан.

Имфинзи худалдааны нэртэй (Дурвалумаб) 500мг/10мл тарилгын уусмал нь ариун чанартай судсанд дусааж хэрэглэдэг концентрацитай уусмал юм. Түүний үндсэн үйлчлэгч бодис нь моноклональ эсрэгбие болох дурвалумаб бөгөөд насанд хүрэгсдэд уушигны жижиг эсийн бус хорт хавдрыг эмчлэхэд хэрэглэгдэг.

Эдгээр хуурамч бүтээгдэхүүнийг хэрхэн таних вэ?

Эдгээр бүтээгдэхүүнүүд нь хуурамч бөгөөд гарал үүсэл, найрлага, эх сурвалжийг санаатайгаар буруу мэдээлсэн.

Жинхэнэ үйлдвэрлэгч AstraZeneca нь хуурамч бүтээгдэхүүнийг харааны мэдрэхүйн олон шалгуураар шалгаад зөрөөтэй болохыг тогтоосон ба энэхүү сэрэмжлүүлэгт дурдсан бүтээгдэхүүнүүд хуурамч болохыг баталсан.

Энэхүү хуурамч бүтээгдэхүүнийг танихын тулд дараах байдлаар шалгах бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтээс харна уу.

- **Lot BAZR** — Энэ нь зөвхөн Бүгд Найрамдах Энэтхэг Улсад түгээх жинхэнэ цувралын дугаар юм. Хуурамч бүтээгдэхүүний сав баглаа боодол болон бичиглэлийн байршил нь зөрүүтэй, зарим бичиглэл байхгүй.
- **Lot BBEG** — Энэ нь зөвхөн Египет улсад түгээх жинхэнэ цувралын дугаар юм. Хуурамч бүтээгдэхүүний сав баглаа боодол болон бичиглэлийн байршил нь зөрүүтэй, зарим бичиглэл байхгүй. Бүтээгдэхүүний үнэ нь (Египет фунтээр) түүнчлэн байхгүй.
- **Lot AVZT** — Энэ цувралын дугаарыг жинхэнэ үйлдвэрлэгч хүлээн зөвшөөрөөгүй. Ийм цувралын дугаартай ямар ч Имфинзи бүтээгдэхүүнийг хуурамч гэж үзсэн.

Эрсдэл

Эдгээр хуурамч бүтээгдэхүүн нь аюултай бөгөөд зарим тохиолдолд амь насанд аюул учруулж болзошгүй. Эдгээр хуурамч Имфинзи худалдааны нэртэй (durvalumab) тарилгын уусмалыг хэрэглэх нь үр нөлөөгүй эсвэл эмчилгээг удаашруулахад хүргэдэг.

Хуурамч Имфинзи худалдааны нэртэй (Дурвалумаб) тарилгын уусмалыг илрүүлэх болон устгах нь эмчлүүлэгчдэд сөрөг үр дагавар гарахаас сэргийлнэ.

Эмнэлгийн мэргэжилтнүүд, Эмийн зохицуулалтын байгууллагууд, олон нийтэд өгөх зөвлөгөө

Эмнэлгийн мэргэжилтнүүд аливаа гаж нөлөө илрэх, эмчилгээ үр дүн муутай байх, хуурамч гэж сэжиглэсэн тохиолдлын талаар Эмийн зохицуулалтын байгууллагад мэдээлэх ёстой. ДЭМБ эдгээр хуурамч бүтээгдэхүүнд өртөж болзошгүй улс орон, бүс нутгуудын нийлүүлэлтийн сүлжээнд хяналт, шалгалтыг нэмэгдүүлэхийг зөвлөж байна. Мөн албан бус/зохицуулалтгүй зах зээлд тавих хяналтыг нэмэгдүүлэхийг зөвлөж байна.

Эмийн зохицуулалтын байгууллага/эрүүл мэндийн байгууллага/хууль сахиулах байгууллагууд тухайн улсад хуурамч бүтээгдэхүүн илэрсэн тохиолдолд


ДЭМБ-д нэн даруй мэдэгдэхийг зөвлөж байна.

Хэрэв танд эдгээр бүтээгдэхүүний аль нэг нь байгаа бол хэрэглэхгүй байхыг ДЭМБ зөвлөж байна.

Хэрвээ та болон таны таньдаг хэн нэгэн уг бүтээгдэхүүнийг хэрэглэсэн буюу хэрэглэсэн байж магадгүй, эсвэл хэрэглэснээр урьдчилан таамаглаагүй гаж нөлөө илэрсэн бол эмнэлгийн мэргэжилтэнд хандахыг зөвлөж байна.

Бүх эмнэлгийн бүтээгдэхүүнийг тусгай зөвшөөрөлтэй ханган нийлүүлэгчдээс авах ёстой. Хэрэв танд эдгээр хуурамч бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн талаар мэдээлэл байвал ДЭМБ-тай rapidalert@who.int хаягаар холбогдоно уу.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ №03/2025

Бүтээгдэхүүний нэр	IMFINZI (durvalumab) injection 500mg/10ml		
Үйлдвэрлэгч	AstraZeneca		
Илэрсэн улс	Исламын Бүгд Найрамдах Иран Улс		Бүгд Найрамдах Турк Улс
Цувралын дугаар	BAZR	BBEG	AVZT
Хүчинтэй хугацаа	03-2025	12-2025	12-2026
Илэрсэн байдал			

СЭРЭМЖЛҮҮЛЭГ №04/2025

ДЭМБ-аас Аргентин улсад стандартын бус "FENTANILO HLB" (фентанилын цитрат) илэрсэн талаар сэрэмжлүүлэг гаргасан байна.


Фентанилын цитратын тарилга нь хүчтэй өвдөлт намдаах үйлчилгээтэй опийн бүлгийн эм бөгөөд мэс заслын үед болон дараа өвдөлт намдаах, архаг өвдөлттэй өвчтөний хүнд хэлбэрийн өвдөлтийг намдаахад хэрэглэдэг.

Аргентин улсад 2025 оны 5-р сард FENTANILO HLB тарилгыг хэрэглэснээс үүдэлтэй үхэлд хүргэсэн бактерийн халдварын дэгдэлт илэрсэн байна. Тухайн тарилга нь эмэнд тэсвэртэй Klebsiella pneumoniae, Ralstonia Picketti бактериар бохирлогдсон байна.

Аргентин улсын Эмийн зохицуулалтын байгууллага (ANMAT) нь 2025 оны 5-р сарын 13-ний өдөр Klebsiella pneumoniae болон Ralstonia Picketti-ийн шинжилгээ эерэг гарсан 31202 цувралын дугаартай "FENTANILO HLB" тарилгын уусмалын талаар сэрэмжлүүлж, эргүүлэн татах мэдэгдэл гаргасан.

ANMAT-ийн сэрэмжлүүлэгт дурдсанаар Аргентин улс дахь "FENTANILO HLB" тарилгын уусмалын маркетингийн зөвшөөрлийг "HLB PHARMA GROUP S.A." эзэмшдэг бөгөөд бүтээгдэхүүнийг "LABORATORIOS RAMALLO S.A" -д гэрээгээр үйлдвэрлүүлсэн байна.

ANMAT нь 2025 оны 2-р сарын 24-нд LABORATORIOS RAMALLO S.A үйлдвэрийн үйл ажиллагаа нь алдаатай, эрсдэлтэйгээс гадна эмийн чанар, аюулгүй байдлыг хангаж



чадахгүй байна гэж үзэн үйлдвэрлэлийг зогсоосон. 2025 оны 5-р сарын 13-нд HLB PHARMA-ийн бүх бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, хэрэглээг хориглосон. Мөн HLB PHARMA болон LABORATORIOS RAMALLO S.A.-ийн үйлдвэрлэсэн өөр олон бүтээгдэхүүнд мөн чанарын ноцтой дутагдал илэрсэн байна.

Дээр дурдсан үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгчийн 2022 оны 2 сараас хойш үйлдвэрлэсэн, түгээсэн бүтээгдэхүүнүүд чанарын шаардлага хангаагүй байх магадлалтай тул болгоомжтой хэрэглэх талаар Аргентин улсын Эмийн зохицуулалтын байгууллага сэрэмжлүүлсэн байна.

Эрсдэл

FENTANILO HLB (фентанилын цитрат) тарилгыг ихэвчлэн хүнд өвчтөнд болон мэс засалд орох өвчтөнүүдэд хэрэглэдэг тул бүтээгдэхүүний чанар болон ариун байдал нь өвчтөний аюулгүй байдалд чухал ач холбогдолтой.

Иймд өвчтөний аюулгүй байдлыг хангах үүднээс эдгээр бүтээгдэхүүнийг зах зээлийн эргэлтэд оруулахаас сэргийлэх шаардлагатай.

Эмнэлгийн мэргэжилтнүүд, Эмийн зохицуулалтын байгууллагууд, олон нийтэд өгөх зөвлөгөө

Эмнэлгийн мэргэжилтнүүд аливаа гаж нөлөө илрэх, эмчилгээ үр дүн муутай байх, эдгээр стандартын бус бүтээгдэхүүн илэрсэн тохиолдлын талаар Эмийн зохицуулалтын байгууллагад мэдээлэх ёстой. ДЭМБ эдгээр стандартын бус бүтээгдэхүүнд өртөж болзошгүй улс орон, бүс нутгуудын нийлүүлэлтийн сүлжээнд хяналт, шалгалтыг нэмэгдүүлэхийг зөвлөж байна. Мөн албан бус/зохицуулалтгүй зах зээлд тавих хяналтыг нэмэгдүүлэхийг зөвлөж байна.

Эмийн зохицуулалтын байгууллага/эрүүл мэндийн байгууллага/хууль сахиулах байгууллагууд хуурамч бүтээгдэхүүн байгаа бол ДЭМБ-д нэн даруй мэдэгдэхийг зөвлөж байна.


Хэрэв танд эдгээр бүтээгдэхүүний аль нэг нь байгаа бол хэрэглэхгүй байхыг ДЭМБ зөвлөж байна.

Хэрвээ та болон таны таньдаг хэн нэгэн уг бүтээгдэхүүнийг хэрэглэсэн буюу хэрэглэсэн байж магадгүй, эсвэл хэрэглэснээр урьдчилан таамаглаагүй гаж нөлөө илэрсэн бол эмнэлгийн мэргэжилтэнд хандахыг зөвлөж байна.

Бүх эмнэлгийн бүтээгдэхүүнийг тусгай зөвшөөрөлтэй ханган нийлүүлэгчдээс авах ёстой. Хэрэв танд эдгээр хуурамч бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн талаар мэдээлэл байвал ДЭМБ-тай rapidalert@who.int хаягаар холбогдоно уу.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ №04/2025

Бүтээгдэхүүний нэр	Fentanilo HLB (fentanilo citrato) 0.05mg/ml					
Бүтээгдэхүүний бүртгэл эзэмшигч	HBL PHARMA GROUP S. A					
Үйлдвэрлэгч	Laboratorios Ramallo S. A					
Илэрсэн улс	Аргентин					
Цувралын дугаар	31200	31202	31244	31245	31246	31247



ТАЙЛАН, СУДАЛГААНЫ АЖИЛ

ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРИЙН ТАРИЛГЫН НУНТАГ ХЭЛБЭРИЙН АНТИБИОТИК ЭМҮҮДИЙН ИДЭВХИЙГ МИКРОБИОЛОГИЙН АРГААР ТОДОРХОЙЛСОН НЬ

Л.Дулмаа¹, Б.Отгонбаатар², Б.Марал², Х.Одонтуяа², Б.Бурмаа²,
Д.Ганчимэг³, Д.Номинцэцэг³, П.Цэцгээ³, Т.Хосбаяр¹

^{1,2,3} Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар

¹Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Үндэслэл

Бичил биетний тэсвэржилт (ББТ) нь Дэлхийн хэмжээнд “Чимээгүй тахал”-д тооцогдож буй бөгөөд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага үүнийг дэлхий нийтийн эрүүл мэндэд тулгарч буй томоохон 10 асуудлын нэг гэж үзэж байна.^{1,2,3} Энэ нь олон хүчин зүйлээс шалтгаалж буй бөгөөд антибиотикийн зохисгүй хэрэглээ болон сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд антибиотикийг шинээр нээж илрүүлээгүй зэрэг нь томоохон шалтгаан болдог байна.^{1,2,4-6}

2023 оны 03 дугаар сард “Nature reviews chemistry” сэтгүүлд нийтлэгдсэн тойм өгүүлэлд металлоантибиотикууд эмнэлзүйн практикт чухал шаардлагатай антибиотикийн шинэ бүлэг болж болох ч зөвхөн шинэ антибиотик хөгжүүлснээр ББТ-ийг шийдвэрлэж чадахгүй бөгөөд эрүүл мэнд, хөдөө аж ахуй болон хүрээлэн буй орчны салбар дахь антибиотикийн хэт болон зохисгүй хэрэглээг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатайг дурдсан⁷ бол зарим судалгаанд ихэвчлэн вирусийн гаралтай үүсгэгддэг амьсгалын замын халдваруудад антибиотикийг жороор бичих нь түгээмэл байгаа бөгөөд үүнээс сэргийлэх арга хэмжээг авснаар антибиотикийн хэрэглээг ихээхэн бууруулж болохыг тэмдэглэсэн байна.^{4,8}

Антибиотикийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэхэд тухайн эм чанартай, аюулгүй, идэвхтэй байх нь эмчилгээний үр дүн гарахад болон тэдгээр эмийн зохистой хэрэглээнд чухал нөлөө үзүүлдэг. Энэ нь үндэсний үйлдвэрийн тарилгын нунтаг хэлбэрийн антибиотик эмийн идэвхийг микробиологийн шингэрүүлэлтийн арга (Цилиндр аяганы буюу нэвчүүлэх арга)-р судлах үндэслэл боллоо.

Зорилго

Үндэсний үйлдвэрийн Цефазолин-Нахиа 1 г, Цефотаксим-Нахиа 1 г, Цефтриаксон-Нахиа 1 г тарилгын нунтаг хэлбэрийн антибиотик эмүүдийн идэвхийг микробиологийн аргаар тодорхойлох.

Арга аргачлал

Судалгаа явуулсан газар: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм шинжлэх лаборатори

Судалгаа явуулсан хугацаа: 2024 оны 8-12 дугаар сарууд

Хими болон микробиологийн шинжилгээнүүдийг Их Британийн Фармакопей (BP)-н аргаар хийж гүйцэтгэлээ.

Химийн шинжилгээ:

Үндсэн үйлчлэгч бодисын агууламжийг тодорхойлох нь:

Судалгаанд “Нахиа” эмийн үйлдвэрийн “Цефазолин-1 г”, “Цефотаксим-1 г” “Цефтриаксон-1 г” тарилгын нунтаг эмүүдийг хамруулсан бөгөөд өндөр идэвхт шингэний хроматографи (HPLC), спектрофотометрийн аргаар үндсэн үйлчлэгч бодисын агууламжийг тус тус тодорхойлсон.

Thermo UltiMate 3000 загварын HPLC багажаар хийсэн шинжилгээний өгөгдлийг Хүснэгт 1-ээр үзүүлэв.

Хүснэгт 1. Thermo UltiMate 3000 загварын HPLC багажаар хийсэн шинжилгээний өгөгдөл

№	Антибиотикийн нэр	Багана	Хөдөлгөөнт фаз	Долгионы урт, нм	Урсгалын хурд, мл/мин
1.	Цефазолин	C18 (ODS)	0.277%Na ₂ HPO ₄ :0.186%C ₆ H ₈ O ₇ (10:90)	270	1
2.	Цефотаксим	C18 (ODS)	3.5г/л KH ₂ PO ₄ +11.6г/лNa ₂ HPO ₄ (pH=7.0)+375 мл CH ₃ OH	235	1


Evolution 300 UV-VIS загварын спектрофотометрийн багажаар хийсэн шинжилгээний өгөгдлийн Хүснэгт 2-оор үзүүлэв.



Хүснэгт 2. Evolution 300 UV-VIS загварын спектрофотометрийн багажаар хийсэн шинжилгээний өгөгдөл

№	Антибиотикийн нэр	Уусгагч	Долгионы урт, нм
1.	Цефтриаксон	H ₂ O	241



Үр дүнг тооцох нь:


- Цефазолины хроматограмм





- Цефотаксимын хроматограмм





Микробиологийн шинжилгээ:

Ариун чанар тодорхойлох:

Шинжилгээний явц:

Асептик нөхцөлд флаконтой эмийн дээж тус бүрийг 0.9 % - 5 мл Натрийн хлоридын ариун уусмалаар найруулан, урьдчилан угсарч бэлтгэсэн вакуум сорогч аппаратаар 0.45 мкм мембран шүүлтүүрээр шүүсэн. Шүүгдэж дуусмагц 100 мл-ийн хэмжээтэй тохирох уусмалаар угааж, дахин шүүв. Шүүж дууссаны дараа мембран шүүлтүүрийг авч, 2 тэнцүү хэсэгт хуваасан. Нэг хэсгийг 100 мл Fluid thioglycollate орчинд, нөгөө хэсгийг Soya-bean casein digest тэжээлт орчинд тус тус хийж, суулгац тус бүрийг 1-2 давталттайгаар хийж, тохирох температурт 14 хоног өсгөвөрлөв.

Үр дүнг тооцсон нь: Fluid thioglycollate broth тэжээлт орчин бүхий суулгацыг 35°C -37°C, Soya-bean casein digest тэжээлт орчныг 22°C-25°C-ийн температурт 14 хоног өсгөвөрлөөд булингар үүссэн эсэхээс хамаарч “ариун” эсэхийг тодорхойлов.

Эмийн жижиг хэсэг тодорхойлох:

Шинжилгээний явц:

Найруулсан дээжнээс 25 мл-ийг хэмжин авч, вакуум сорогч аппаратаар цаасан мембран фильтр ашиглан шүүсэн. Шүүгдэж дуусмагц 25 мл цэвэршүүлсэн ариун усаар дахин шүүгээд мембран фильтрийг авч, нимгэн глицериний давхарга бүхий петрийн аяганд хийв. Петрийн аягатай мембран фильтрийг ламинар боксонд тавьж тасалгааны температурт хатаалаа. Мембран фильтр бүрэн хатаж дуусмагц микроскопийн тохирох өсгөлт дээр тааруулан үл уусах жижиг хэсгийн хэмжээг тоолсон.

Үр дүнг тооцсон нь: Дээжийн хэмжээнээс хамаарч шалгуурын шаардлагыг тогтоохдоо Хүснэгт 3-т заасны дагуу үнэлэв.

Хүснэгт 3. Дээжийн хэмжээнээс хамаарсан шалгуурын шаардлага

Дээжийн хэмжээ	Шаардлага
100 мл-ээс бага эзэлхүүнтэй шингэн	10 мкм-т 25-с ихгүй 25 мкм-т 3-с ихгүй
100 мл-тэй тэнцүү буюу түүнээс их эзэлхүүнтэй шингэн	10 мкм-т 6000-с ихгүй 25 мкм-т 600-с ихгүй

Антибиотикийн идэвх тодорхойлох:

Судалгааг микробиологийн шингэрүүлэлтийн арга (Цилиндр аяганы буюу нэвчүүлэх арга)-аар хийж гүйцэтгэсэн ба судалгаанд "Sigma-Aldrich" (<https://www.sigmaaldrich.com>) байгууллагаас худалдаж авсан C0682800 код бүхий Цефазолин, C0685000 код бүхий Цефотаксим, C0691000 код бүхий Цефтриаксоны стандарт бодисууд, Биотехнологийн "ATCC" байгууллагаас худалдаж авсан 6633 код бүхий Bacillus subtilis (<https://www.atcc.org/products/6633>) омгийг тус тус ашиглав.

Дээжийг бэлтгэх:

А уусмал: 1 флакон дээжийг 100 мл хэмжээст колбонд хийж фосфатын буферээр шингэлсэн.

В уусмал: А уусмалаас 10 мл-ийг авч 100 мл-т шингэлэв.

С уусмал: В уусмалаас 1 мл-ийг авч 10 мл-т шингэлэв. Энэ уусмал нь 0.1мг/мл концентрацитай (Т) болов.

Стандарт уусмал бэлтгэх:

10 мг стандарт бодис авч 10 мл-ийн хэмжээст колбонд фосфатын буферээр шингэлж бэлтгэсэн. Жиших муруйг 5 цэгээр (S_1, S_2, S_3, S_4, S_5) байгуулж, S_3 концентрацийг 0.1мг/мл байлгахар бэлтгэв.

Тест бичил биет бэлтгэх:

24 цагийн Bacillus subtilis-ийн өсгөврөөс 0.9%-ийн Натрийн хлоридын уусмалд суспенз бэлтгэв. MacFarland 1 уусмалтай харьцуулан бэлтгэсэн.

Шинжилгээний явц:

Bacillus agar тэжээлт орчны гадаргуу дээр 0.1 мл-ээр Bacillus subtitles-ийн өсгөврөөс тарилт хийж сайтар нэвчүүлэн, гадаргуу дээр peni цилиндр байрлууллаа. $S_1, S_2, S_3, S_4, S_5, T$ тус тус 3 давталттай тарилт хийж 35°C-ийн термостатад хийж өсгөврөлөв.

Үр дүнг тооцсон нь:

Хүрээний их, бага утгыг дараах томъёогоор тооцов. $L = \frac{3a+2b+c-e}{5}$; $H = \frac{3e+2d+c-a}{5}$
Антибиотикийн идэвхийг дараах томъёогоор тооцлоо.

Үр дүн

Үндэсний үйлдвэрийн тарилгын нунтаг хэлбэрийн 3 нэрийн антибиотик эмэнд хийсэн шинжилгээний үр дүнг Хүснэгт 4, 5, 6-аар харуулав.

$$x = \frac{T * A_{st} * V_p * C_{st} * K\%}{S * A_p * V_{st} * C_p * P} * 100\%$$

Хүснэгт 4. Цефазолин эмийн шинжилгээний үр дүн


Шинжлэх үзүүлэлт	Арга	Шаардагдах ба зөвшөөрөгдөх хэмжээ	Шинжилгээний үр дүн
Гадна байдал**	Мэдрэхүйн арга		Цагаан нунтаг
Таних урвал /Өнгөт урвал/	Ерөнхий урвалаар	Натри	Өгсөн
Таних урвал /СФМ-ийн арга/	СФМ-ийн арга	Цефазолин	Өгсөн
Дундаж жин	Жингийн арга		1.05 г
Уусмалын орчин	Потенциометрийн арга	4.0-6.0	5.0
Тооны тодорхойлолт /СФМ-н арга/	спектрофотометрийн арга	Цефазолин 90.0-105.0%	97.1%
Эмийн бодисын жижиг хэсгийн	Микроскопийн арга	10мкм ≤ 6000 25мкм ≤ 600	4 0
Ариун чанар	Биологийн арга	Ариун чанартай	Ариун чанартай
Антибиотикийн идэвх	Биологийн арга	90-105.0%	102.21%

Хүснэгт 5. Цефотаксим эмийн шинжилгээний үр дүн

Шинжлэх үзүүлэлт	Арга	Шаардагдах ба зөвшөөрөгдөх хэмжээ	Шинжилгээний үр дүн
Гадна байдал**	Мэдрэхүйн арга		Шаравтар туяатай цагаан өнгийн үнэргүй нунтаг
Таних урвал /Өнгөт урвал/	Ерөнхий урвалаар	Натри	Өгсөн
Таних урвал /СФМ-ийн арга/	СФМ-ийн арга	Цефотаксим	Өгсөн
Дундаж жин	Жингийн арга		1.1165 г
Уусмалын орчин	Потенциометрийн арга	4.5-6.5	5.6
Уусмалын өнгө, тунгалаг чанар	Харьцуулах арга	0.6-с ихгүй	0.1
Тооны тодорхойлолт /СФМ-н арга/	Спектрофотометрийн арга	Цефотаксим 90.0-110.0%	100.8%
Жингийн алдагдал	Физикийн арга	3.0%-с ихгүй	2.6%
Эмийн бодисын жижиг хэсгийн	Микроскопийн арга	10мкм ≤ 6000 25мкм ≤ 600	0 2
Ариун чанар	Биологийн арга	Ариун чанартай	Ариун чанартай
Антибиотикийн идэвхи	Биологийн арга	90-110.0%	92.78%

Хүснэгт 6. Цефтриаксон эмийн шинжилгээний үр дүн

Шинжлэх үзүүлэлт	Шинжилгээний арга	Зөвшөөрөгдөх хэмжээ	Шинжилгээний үр дүн
Гадна байдал**	Мэдрэхүйн арга		Цагаан өнгийн үнэргүй нунтаг
Таних урвал /Өнгөт урвал/	Ерөнхий урвалаар	Натри	Өгсөн
Таних урвал /СФМ-ийн арга/	СФМ-ийн арга	Цефтриаксон	Өгсөн
Дундаж жин	Жингийн арга		1.1868 г



Уусмалын орчин	Потенциометрийн арга	6.0-8.0	6.3
Уусмалын өнгө, тунгалаг чанар	Харьцуулах арга	Y5 эсвэл BY5-с тодгүй	Y5-с тодгүй
Тооны тодорхойлолт / CFM-н арга/	Спектрофотометрийн арга	Цефтриаксон 92.0-108.0%	107.10%
Эмийн бодисын жижиг хэсгийн	Микроскопийн арга	10мкм ≤ 6000 25мкм ≤ 600	4 0
Ариун чанар	Биологийн арга	Ариун чанартай	Ариун чанартай
Антибиотикийн идэвх	Биологийн арга	92-108.0%	94.74%

Дүгнэлт

1. Үндэсний үйлдвэрийн Цефазолин-Нахиа 1 г, Цефотаксим-Нахиа 1 г, Цефтриаксон-Нахиа 1 г тарилгын нунтаг хэлбэрийн антибиотик эмүүд нь хими болон микробиологийн шинжилгээгээр Их Британийн фармакопейнXXXXX шаардлага хангаж байна.
2. Цефазолин-Нахиа 1 г, Цефотаксим-Нахиа 1 г, Цефтриаксон-Нахиа 1 г тарилгын нунтаг хэлбэрийн антибиотик эмүүдийн идэвхийг Микробиологийн шингэрүүлэлтийн аргаар тодорхойлоход 102.21%, 92.78%, 94.74% тус тус байсан нь Их Британийн фармакопейн шаардлага хангаж байна.

Эх сурвалж:

1. Tang, K. W. K., Millar, B. C., & Moore, J. E. (2023). Antimicrobial Resistance (AMR). *British Journal of Biomedical Science*, 80, 11387.
2. Walsh, T. R., Gales, A. C., Laxminarayan, R., & Dodd, P. C. (2023). Antimicrobial Resistance: Addressing a Global Threat to Humanity. *PLoS Medicine*, 20(7), e1004264.
3. Magnano San Lio, R., Favara, G., Maugeri, A., Barchitta, M., & Agodi, A. (2023). How antimicrobial resistance is linked to climate change: an overview of two intertwined global challenges. *International journal of environmental research and public health*, 20(3), 1681.
4. Burstein, V. R., Trajano, R. P., Kravitz, R. L., Bell, R. A., Vora, D., & May, L. S. (2019). Communication interventions to promote the public's awareness of antibiotics: a systematic review. *BMC public health*, 19, 1-11.
5. Mathew, P., Sivaraman, S., & Chandy, S. (2019). Communication strategies for improving public awareness on appropriate antibiotic use: Bridging a vital gap for action on antibiotic resistance. *Journal of family medicine and primary care*, 8(6), 1867.
6. Walesch, S., Birkelbach, J., Jézéquel, G., Haeckl, F. J., Hegemann, J. D., Hestekamp, T., ... & Müller, R. (2023). Fighting antibiotic resistance-strategies and (pre) clinical developments to find new antibacterials. *EMBO reports*, 24(1), e56033.
7. Frei, A., Verderosa, A. D., Elliott, A. G., Zuegg, J., & Blaskovich, M. A. (2023). Metals to combat antimicrobial resistance. *Nature Reviews Chemistry*, 7(3), 202-224.
8. Cross, E. L. A., Tolfree, R., & Kipping, R. (2017). Systematic review of public-targeted communication interventions to improve antibiotic use. *Journal of Antimicrobial Chemotherapy*, 72(4), 975-987.

Т.Тунгалаг¹, С.Пүрэвсүрэн², С.Мөнхбат³, Т.Мөнхтуул⁴



МОНГОЛ УЛСЫН ЭМИЙН БҮРТГЭЛД БҮРТГЭГДСЭН ЕРӨНХИЙ НЭРШЛИЙН ЭМИЙН БИОЭКВИВАЛЕНТ ЧАНАРЫН СУДАЛГАА БАЙДАЛД ҮНЭЛЭЛТ ӨГӨХ НЬ

¹АШУУИС, Эм зүйн сургууль

²ЭЭХХЗГ-ын, Эмийн аюулгүй байдлын тандалт судалгааны газар

Email: tungaa7764@gmail.com

Утас: 976-99037764

Үндэслэл: Эмийг үйлдвэрлэх технологи, эмийн түүхий эдийн физик химийн шинж чанар, эмийн идэвхт бүрэлдэхүүний цэвэршилтийн зэрэг гэх мэт олон хүчин зүйлээс эмийн биохүрэхүй хамаарч, улмаар эмчилгээний үр дүнд нөлөөлдөг. Зах зээлд эмчилгээний үр дүн муутай эм нэвтэрснээр эмнэлгийн тусламжийн чанар буурах, эмчлүүлэгчийн өвчтэй байх хугацаа уртсах, өвчний явц хүндрэх зэрэг олон сөрөг үр дагаварт хүргэдэг тул улс орнууд ерөнхий нэршлийн эмийг бүртгэхэд биоэквивалент чанарын судалгааг шаардаж, чанарын баталгаатай ерөнхий нэршлийн эмийн хэрэглээг дэмжих, ерөнхий нэршлийн эмийг харилцан орлуулан хэрэглэх боломжийг сайжруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлдэг.

Монгол улсын эмийн бүртгэлд эмийг эмчилгээний идэвхийг нь харгалзан бүртгэж буй эсэхэд дүн шинжилгээ хийж, эмийн бүртгэлийг сайжруулах шаардлагатай байгаа нь энэхүү судалгааны үндэслэл болж байна.

Судалгааны ажлын зорилго: Монгол улсын эмийн бүртгэлд ерөнхий нэршлийн эмийг биоэквивалент чанарын судалгаанд үндэслэн бүртгэсэн байдалд үнэлэлт өгөх.

Судалгааны ажлын зорилт:

1. Шинээр бүртгэгдсэн ерөнхий нэршлийн шахмал, капсултай эмэнд биоэквивалент чанарын судалгаа хийсэн байдлыг тогтоох
2. Биоэквивалент чанарын судалгаанд үнэлгээ өгөх


Судалгааны ажлын материал арга зүй: Баримтын судалгааг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын архивд хадгалагдаж буй эмийн бүртгэлийн материалд хийв. 2020, 2021 онд бүртгэгдсэн ерөнхий нэршлийн 108 эмийн бүртгэлийн материалаас судалгааны мэдээллийг 34 асуулт бүхий судалгааны картаар цуглуулсан. Үр дүнгийн тоон үзүүлэлтийн статистик боловсруулалтыг SPSS-26 программаар хийж, чанарын хувьсагчдад давтамж, эзлэх хувийг тус тус тооцов. Биоэквивалент чанарын судалгаа хийсэн эсэхэд нөлөөлөх хүчин зүйлийн хамаарлыг пирсоны корреляциар тооцож, $r < 0.3$ бол сул, $0.3-0.5$ бол дунд зэргийн хамааралтай гэж үзсэн. $p < 0.05$ байгаа үед статистик ач холбогдол бүхий ялгаатай гэж үзэв.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан 108 эмээс 45 (41.6%) эмэнд биоэквивалент чанарын судалгаа хийгдсэн, 63 (58.4%) эмэнд хийгдээгүй, 60.2%-ийг шахмал эм, 89.8%-ийг жороор олгох эм эзэлж байна. Судалгаанд хамрагдсан эмүүдийг үйлдвэрлэсэн улсаар авч үзэхэд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын 24 (22.2%), БНСУ-ын 13 (12%) БНЭУ-ын 12 (11.1%) эм байна. Биоэквивалент чанарын судалгаа хийгдсэн эмэнд БНСУ-д үйлдвэрлэгдсэн эмүүд хамгийн их хувийг буюу 28.9%-ийг эзэлж байв. Биоэквивалент чанарын судалгаа хийсэн эсэх нь тухайн эмийг үйлдвэрлэсэн улстай статистик ач холбогдол бүхий сул хамааралтай байна ($r=0.262$, $p < 0.01$).

Хүснэгт 1. Биоэквивалент чанарын судалгаа хийгдсэн эмүүдийн биоэквивалент эсэх

Биоэквивалент эсэх	N	%
Биоэквивалент	38	84.4
Тодорхойгүй	7	15.6
Нийт	45	100.0

Зураг 1. Биоэквивалент чанарын судалгаа хийгдсэн байдал



Судалгаанд хамрагдсан эмийг АТС кодын ангиллаар авч үзвэл судалгаанд хамрагдсан болон биоэквивалент чанарын судалгаа хийгдсэн эмэнд Зүрх судасны тогтолцооны эмгэгт хэрэглэх эм 30 (27.8%) байна. Судалгаанд хамрагдсан эмүүдийг найрлагаар авч үзэхэд нийт эмийн 88 (81.5%), биоэквивалент чанарын судалгаа хийгдсэн эмүүдийн 37 (82.2%) нь дан найрлагатай эм байв. Судалгаанд хамрагдсан дан найрлагатай эмийг Биофармацийн ангиллын системийн бүлгээр авч үзэхэд 79.5%-д II бүлгийн буюу муу уусдаг, сайн нэвчдэг эм, 5.6%-ийг бүлгийг нь тодорхойлох боломжгүй эм эзэлж байна. Дан найрлагатай эмүүдийг Биофармацийн ангиллын системд суурилсан биохасалт хийх боломжтой эмүүдийн жагсаалтад орсон эсэхийг холбогдох эх сурвалжаас тодруулахад биоэквивалент чанарын судалгаа хийгдсэн эмийн 51.3%, биоэквивалент чанарын судалгаа хийгдээгүй эмийн 55.6%-д биохасалт хийх боломжтой байв. Биоэквивалент чанарын судалгаа хийгдсэн эмийн 42.2%-д биоэквивалент чанарын судалгаанд ашигласан удирдамжийг заагаагүй, 27 (61.4%)-д өөр үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүнийг ашигласан байна. Биоэквивалент чанарын судалгаа хийгдсэн эмийн 79.5%-д ин виво аргаар, 20.5%-д ин витро болон ин виво аргыг хослуулан эквивалент чанарын судалгааг хийжээ. Судалгаа хийсэн арга нь эмийн хэлбэртэй статистик ач холбогдол бүхий дунд зэргийн хамааралтай байна ($r=0.458$, $p<0.01$). Ин витро аргаар уусалтын харьцуулсан судалгаа хийгдсэн бол ин виво аргаар судалгаа хийгдсэн эмийн 38 (84.4%)-д фармакокинетикийн арга ашигласан, 48.9%-д AUC, Cmax үзүүлэлтийг тодорхойлсон байна. Биоэквивалент чанарын судалгаанд 2 дараалалт солбисон загварыг 80%-д буюу хамгийн их хэрэглэсэн ба нийт биоэквивалент чанарын судалгаа хийгдсэн 45 эмийн 84.4%-д биоэквивалент болохыг тогтоосон байв.

Дүгнэлт:

1. Судалгаанд хамрагдсан 108 эмийн 58.4%-д биоэквивалентын чанарын судалгааны үр дүнг бүртгэлийн материалд ирүүлээгүй байгаа нь Монгол улсын эмийн бүртгэлд ерөнхий нэршлийн эмийг биоэквивалент чанарт үндэслэн бүртгэдэггүй болохыг харуулж байгаа байна.
2. Биоэквивалент чанарын судалгааны материал ирүүлсэн ерөнхий нэршлийн 45 эмийн 80%-д ин виво аргыг, 20%-д ин виво ба ин витро аргыг хослуулан судалгааг хийсэн байна. Биоэквивалент чанарын судалгааны судалгаа хийгдсэн эмийн 84.4%-д биоэквивалент болохыг нотолсон байна.

Түлхүүр үг: ерөнхий нэршлийн эм, биоэквивалент чанар, биохүрэхүй, эмийн бүртгэл

ДАРХЛААЖУУЛАЛТЫН ДАРААХ УРВАЛ ХҮНДРЭЛ/ДДУХ/-ийн 2021-2025 ОНЫ МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ


Ц.Амаржаргал Нийгмийн удирдлагын магистр ЭЭХХЗГ-ын
/Вакцин, биобэлдмэлийн чанар, аюулгүй байдал,
зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн/

Хүн амыг халдварт өвчнөөс сэргийлэх, түүний тархалтыг хязгаарлах, өвчнийг устгах зорилгоор дархлаажуулах бэлдмэл хэрэглэх арга хэмжээний тогтолцоог халдварт өвчний эсрэг дархлаажуулалт гэдэг. Дархлаажуулалтын дараа дархлаажуулалтын үйл ажиллагааны алдаа, вакцины чанар, хадгалалт, тээвэрлэлтээс үүдэлтэй эсвэл эрүүл мэндийн эмгэг байдалтай холбоотой болон шалтгаан тодорхойгүйгээр дархлаажуулалтын дараах урвал хүндрэл (ДДУХ) илэрч болдог.

Монгол Улсад дархлаажуулалтын үйл ажиллагааг зохицуулахад дараах хууль, журмын заалтуудыг баримтлан ажиллаж байна. Үүнд:


- 2000 онд батлагдсан “Дархлаажуулалтын тухай” хууль, түүнчлэн 2022 онд энэхүү хуулийн 16.1 заалтад “Дархлаажуулах бэлдмэлийн чанар, хадгалалт, тээвэрлэлт болон аюулгүй байдлын талаар тавих улсын хяналтыг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага болон тухайн эрүүл мэндийн байгууллага дотоод хяналтаар хэрэгжүүлнэ.”, 20.1 заалтад “Тарилгын дараах хүндрэлийг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, эмчилгээний чанарын хяналтын байцаагч магадлан тогтооно.” гэж тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ЭМС-ын 2012 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Дархлаажуулалтын тухай” 217 дугаар тушаал, 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн “Журамд өөрчлөлт оруулах тухай” А/278 дугаар тушаалаар баталсан Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл(ДДУХ)-ийг бүртгэх, мэдээлэх, тандах журмыг мөрдөж байна.
- ЭМС-ын 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/527 дугаар тушаалаар баталсан “Халдварт өвчний тохиолдлыг тандах журам”-ын гуравдугаар хавсралтаар ДДУХ-ийг яаралтай мэдээлэх хуудсыг баталсан.
- ЭМС-ын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/67 дугаар тушаалаар “Эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх, үнэлэх, тайлагнах” журмын 2.3 дахь заалтад “Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл(ДДУХ)-ийн мэдээллийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын алба улсын хэмжээнд нэгтгэн бүртгэж, дүн шинжилгээ хийж, батлагдсан болон сэжигтэй бүх тохиолдлыг сар бүрийн эхний 5 өдөрт багтаан и-мэйлээр болон Вижифлоу(Vigiflow) үндэсний мэдээний санд бүртгэх ажлыг хариуцан гүйцэтгэнэ.” Мөн 4.1.4-т ДДУХ-ийн тохиолдлыг үндэсний мэдээний санд Вижифлоу (Vigiflow) бүртгэх ажлыг ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын алба, олон улсын Вижилайс (Vigilyze) системд мэдээлэх ажлыг ЭЭХХЗГ-ын хариуцсан мэргэжилтэн тус тус хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан.
- 2023 оны “Эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх, үнэлэх, тайлагнах” журам нь 2024 онд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотой 2025 оны 06 сарын 06-ны Эм, эмнэлгийн хяналт, зохицуулалтын газрын даргын А/128 дугаар тушаалаар “Фармаковижилансын үйл ажиллагааг зохицуулах” журам болж батлагдсан. Энэхүү журмын 2.2 дахь заалт болон хоёрдугаар хавсралтын 3-т заасан урсгалын дагуу ДДУХ-ийг бүртгэн мэдээлнэ.

Дээрх журмын хэрэгжилтийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс манай байгууллагад 2021-2025 онд ирүүлсэн ДДУХ-ийн мэдээллийг нэгтгэж дүгнэсэн. Энэ онуудад нийт 104 ДДУХ-ийн тохиолдлын мэдээлэл ирсэн байна.



Зураг 1: Мэдээлэгдсэн ДДУХ-ийн тохиолдол /он, тоогоор/

ДДУХ-ийн 104 тохиолдлыг хэрэглэсэн вакцины төрлөөр ангилж үзэхэд Тавт(Сахуу, хөхүүл ханиад, татран, В гепатит, хемофилюс инфлюэнза В) вакцин, гепатит А,В-ийн эсрэг вакцин, Сахуу татрангийн эсрэг, Халдварт саагийн эсрэг, Улаан бурхан, гахайн хавдар, улаанууд (УГУ)-ын эсрэг, Сүрьеэгийн эсрэг, Пневмококкын эсрэг товлोलт вакцинуудын ДДУХ 54 тохиолдол буюу 51,9 хувийг нь эзэлж байна. Товлолын бус вакцинуудын ДДУХ 50 тохиолдол буюу 48,1 хувийг эзэлж байна. Товлолын бус вакцины 50 тохиолдлын 41 тохиолдол нь Коронавируст халдвар (SARS-CoV-2)-ын эсрэг вакцинжуулалтын дараа гарсан ДДУХ байсан байна.



Зураг 2: ДДУХ-ийн тохиолдол/вакцины төрлөөр/

ДДУХ-ийн мэдээллийн 44,2 хувь буюу 46 тохиолдлын нийслэлийн 8 дүүргээс, 51,9 хувь буюу 54 тохиолдлыг 18 аймгаас, 4 тохиолдлыг Хүрээ амаржих газар 1, Цэргийн төв эмнэлэг 2, цэргийн анги 1 тохиолдлыг тус тус мэдээлсэн байна.


Хүснэгт 3: ДДУХ-ийн мэдээ өгсөн байгууллагууд

№	Байгууллага	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он	НИЙТ
1	Багануур дүүрэг		3	1			4
2	Баянзүрх дүүрэг	2	3	5		1	11
3	Баянгол дүүрэг			1		1	2
4	Налайх дүүрэг				3		3
5	Сүхбаатар дүүрэг	3			2		5
6	Сонгинохайрхан дүүрэг	3	3	1	1	2	10
7	Чингэлтэй дүүрэг	1	1	1			3
8	Хан-Уул дүүрэг	3	1			4	8
9	Баян-Өлгий аймаг	1		1	1		3
10	Баянхонгор аймаг			1	1		2
11	Булган аймаг	1					1
12	Говь-Алтай аймаг	1		1			2
13	Говьсүмбэр аймаг					1	1
14	Дархан аймаг				1		1
15	Дундговь аймаг		1	1			2
16	Дорнод аймаг	1		1			2
17	Завхан, Сонгино сум ЗХ 274-р анги	1					1
18	Завхан аймаг	5				1	6
19	Орхон аймаг			1	1		2
20	Өвөрхангай аймаг	2	1				3
21	Өмнөговь аймаг	1	4		2	2	9
22	Сүхбаатар аймаг	2	1	2			5
23	Сэлэнгэ аймаг	2			1		3
24	Төв аймаг	1					1
25	Увс аймаг	1		5			6
26	Ховд аймаг	1		1			2
27	Хөвсгөл аймаг	2				1	3
28	Хүрээ амаржих газар	1					1
29	Цэргийн төв эмнэлэг	2					2
Нийт		37	18	23	13	13	104

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь 2021 оны 10 дугаар сард УППСАЛА дахь олон улсын эмийн хяналтын төвд 149 дэх жинхэнэ гишүүн орноор элсэн орж, Монгол улсад бүртгэгдсэн эмийн гаж нөлөө, вакцины урвал хүндрэлийг үндэсний болон олон улсын мэдээний санд бүртгэж, олон улсаас эм, вакцины аюулгүй байдлын дохио мэдээ хүлээн авч мэдээлэл солилцон ажиллах нөхцөл бүрдсэн.

Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг (ДДУХ) олон улсад мэдээлэхтэй холбоотой эрх зүйн орчныг шинэчлэх, улсын хэмжээнд ДДУХ бүртгэн мэдээлэх үйл


ажиллагаанд e-Reporting цахим системийн хэрэглээг нэвтрүүлж, үндэсний (Vigiflow) болон олон улсын (Vigilyze) нэгдсэн мэдээний санг хэрэглэж байна.



Зураг 4: Уппсала олон улсын хяналтын төвд мэдээлсэн ДДУХ-ийн тохиолдол/тоогоор/

ДДУХ-ийн мэдээлэгдсэн тохиолдлыг он тус бүрээр тодруулж үзвэл:

- 2021 онд Ковид-19 халдварын эсрэг вакцинтай холбоотой ДДУХ-ийн нийт 37 тохиолдол 20 эрүүл мэндийн байгууллагаас мэдээлэгдсэн байна. Ковид-19 халдварын эсрэг вакцины хувьд 1-р тун авсны дараа 22, 2-р тун авсны дараа 12, 3-р тун авсны дараа 3 ДДУХ мэдээлэгдсэн байна. Хүснэгтээр Ковид-19 халдварын эсрэг хэрэглэсэн вакцины нэршлээр нийт ДДУХ-ийн тохиолдлын хэдэн хувийг эзэлж байгааг харуулсан.



Зураг 5: Ковид-19 халдварын эсрэг вакцины ДДУХ-ийн тохиолдол/нэр төрлөөр/

- 2022 онд нийт 18 ДДУХ-ийн тохиолдлыг мэдээллэсний 5 нь дүүрэг, 4 нь аймгаас байна. Мэдээллийг дүгнэж үзэхэд ДДУХ 18 тохиолдлын 8 нь буюу хамгийн олон нь Тавт вакцин үүнээс 5 нь 1-р тун авсны дараа гарсан урвал хүндрэл байна. ДДУХ-ийн 18 тохиолдлын 5 нь эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн.

Хүснэгт 6: ДДУХ-ийн мэдээ 2022 он/вакцины төрөл, байгууллагаар/

№	Байгууллага	Тавт		Ковид	Саа	СТ	Томуу	
		I тун	II тун	II тун	II тун	II тун	I тун	бүгд
1	БНД	2	1					3
2	БЗД	1				1	1	3
3	ЧД						1	1
4	СХД	1		2				3
5	ХУД				1			1
6	Өмнөговь		1	2			1	4
7	Өвөрхангай		1					1
8	Дундговь					1		1
9	Сүхбаатар	1						1
Бүгд		5	3	4	1	2	3	18

3. 2023 онд нийт 23 ДДУХ-ийн тохиолдол мэдээлэгдсэн байна. Мэдээг нийслэлийн 4 дүүрэг, 9 аймгаас ирүүлсэн байна. Үүнээс 8 тохиолдол нь товллын Тавт вакцин хэрэглэсний дараа гарсан бөгөөд 4 нь I тун авсны дараа 4 нь II тун авсны дараа гарсан урвал хүндрэл байсан байна. Мэдээлэл ирүүлсэн газрыг авч үзэхэд Увс аймгаас 5, Сүхбаатар аймгаас 2, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Дундговь, Дорнод, Орхон аймгаас тус тус 1, нийслэлийн Баянзүрх дүүргээс 6, Багануур, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргээс тус тус 1 ДДУХ мэдээлсэн байна.

Жишээ болгоход Увс аймгаас ДДУХ-ийн 5 тохиолдлыг мэдээлсний 3 нь Сагил сум, 1 нь Өмнөговь сум, 1 нь Улаангом сумаас мэдээлэгдсэн байна.

Хүснэгт 7: ДДУХ-ийн мэдээ 2023 он/вакцины төрөл, байгууллагаар/

№	Байгууллага	Тавт		Ковид	Саа	СТ	Томуу	
		I тун	II тун	II тун	II тун	II тун	I тун	бүгд
1	БНД	2	1					3
2	БЗД	1				1	1	3
3	ЧД						1	1
4	СХД	1		2				3
5	ХУД				1			1
6	Өмнөговь		1	2			1	4
7	Өвөрхангай		1					1
8	Дундговь					1		1
9	Сүхбаатар	1						1
Бүгд		5	3	4	1	2	3	18

4. 2024 онд нийт 13 ДДУХ-ийн тохиолдол мэдээлэгдсэн байна. Мэдээг нийслэлийн 3 дүүрэг, 6 аймгаас ирүүлсэн байна. Үүнээс 5 тохиолдол нь товллын Тавт вакцин хэрэглэсний дараа гарсан бөгөөд 2 нь I тун авсны дараа 3 нь II тун авсны дараа гарсан урвал хүндрэл байсан байна.

Хүснэгт 8: ДДУХ-ийн мэдээ 2024 он/вакцины төрөл, байгууллагаар/

Байгууллага	Тавт		УГУ		Сахуу, татран		ХПВ	Нийт
	I тун	II тун	I тун	II тун	I тун	II тун		
1 Сүхбаатар дүүрэг		1					1	2
2 Налайх дүүрэг				1	2			3
3 Баянхонгор аймаг		1						1
4 Баян-Өлгий аймаг			1					1
5 Сонгинохайрхан дүүрэг						1		1
6 Дархан аймаг					1			1
7 Орхон аймаг	1							1
8 Сэлэнгэ аймаг							1	1
9 Өмнөговь аймаг	1	1						2
Нийт	2	3	1	1	3	1	2	13

5. 2025 онд нийт 13 ДДУХ-ийн тохиолдол мэдээлэгдсэн байна. Мэдээг нийслэлийн 4 дүүрэг, 4 аймгаас ирүүлсэн байна. Үүнээс 4 тохиолдол нь товллын Тавт вакцин хэрэглэсний дараа гарсан бөгөөд 2 нь I тун авсны дараа 2 нь II тун авсны дараа гарсан урвал хүндрэл байсан байна.

Байгууллага	Тавт		Сахуу, татран		БЦЖ	ХПВ	Томуу	Улаан бурхан	Нийт
	I тун	II тун	I тун	II тун					
1 Баянгол дүүрэг					1				1
2 Баянзүрх дүүрэг		1							1
3 Сонгинохайрхан дүүрэг	1	1							2
4 Хан-Уул дүүрэг			1	2		1			4
5 Говьсүмбэр аймаг					1				1
6 Завхан аймаг							1		1
7 Хөвсгөл аймаг								1	1
8 Өмнөговь аймаг	1					1			2
Нийт	2	2	1	2	2	2	1	1	13

ФАРМАКОПЕЙН ХОРООНЫ 2023-2025 ОНЫ ХУРАЛ

Н.Галзул ЭЭХХЗГ-ын
/Шинэ эм, инновацийн асуудал хариуцсан мэргэжилтэн/

Фармакопейн хорооны 2023 оны хурал

№	Огноо	Хэлэлцүүлсэн				Шийдвэр		Байгууллагын тоо	Тайлбар
		Шинээр хэлэлцүүлэх	Өөрчлөлт оруулах	Хугацаа сунгуулах	Нийт ҮФӨ тоо	Дэмжигдсэн	Дахин хэлэлцүүлэх		
1	2023.03.29	4	-	2	6	6	-	3	Нийт 2 удаагийн хурлаар 5 эмийн үйлдвэрийн 17 нэрийн бүтээгдэхүүний ҮФӨ хэлэлцүүлсэн. Үүнээс шинээр хэлэлцүүлэх 4 ҮФӨ, хугацаа сунгуулсан 13 ҮФӨ байна. Хурлын шийдвэрээр 17 ҮФӨ дэмжигдсэн байна.
2	2023.12.01	-	-	11	11	11	-		
3	Нийт	4	0	13	17	17	0		

Фармакопейн хорооны 2024 оны хурал

№	Огноо	Хэлэлцүүлсэн				Шийдвэр		Байгууллагын тоо	Тайлбар
		Шинээр хэлэлцүүлэх	Өөрчлөлт оруулах	Хугацаа сунгуулах	Нийт ҮФӨ тоо	Дэмжигдсэн	Дахин хэлэлцүүлэх		
1	2024.05.07	2	-	4	6	5	1	3	1 удаагийн хуралаар 3 эмийн үйлдвэрийн 6 нэрийн бүтээгдэхүүний ҮФӨ хэлэлцүүлсэн. Үүнээс шинээр хэлэлцүүлэх 2 ҮФӨ, хугацаа сунгуулсан 4 ҮФӨ байна. Хурлын шийдвэрээр 5 ҮФӨ дэмжигдэж, 1 ҮФӨ дахин хэлэлцүүлэхээр буцаагдсан байна.
2	Нийт	2	0	4	6	5	1		

Фармакопейн хорооны 2025 оны хурал

№	Огноо	Хэлэлцүүлсэн			Шийдвэр		Байгууллагын тоо	Тайлбар	
		Шинээр хэлэлцүүлэх	Өөрчлөлт оруулах	Хугацаа сунгуулах	Нийт ҮФӨ тоо	Дэмжигдсэн Дахин хэлэлцүүлэх			
1	2025.04.11	1	-	7	8	7	1 шинэ	4	2 удаагийн хурлаар 8 эмийн үйлдвэрийн 21 нэрийн бүтээгдэхүүний ҮФӨ хэлэлцүүлсэн.
2	2025.07.03	5	-	8	13	13	-	6	
3	Нийт	6	-	15	21	20	1	8 /давхардсан/	Үүнээс шинээр хэлэлцүүлэх 6 ҮФӨ, хугацаа сунгуулсан 15 ҮФӨ байна. Хурлын шийдвэрээр 1 шинэ ҮФӨ дахин хэлэлцүүлэхээр буцаагдаж, 20 ҮФӨ дэмжигдсэн байна.

ШИНЭ АНТИБИОТИК ЭМИЙН МЭДЭЭЛЭЛ

С.Ганболор ЭЭХХЗГ-ын
/Нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээний
асуудал хариуцсан мэргэжилтэн/

Шээс дамжуулах замын халдварын үед хэрэглэгдэх шинэ антибиотикийг АНУ-ын Хүнс эмийн агентлагаас баталгаажууллаа.

АНУ-ын Хүнс, эмийн агентлагаас эмэгтэйчүүд болон 12 түүнээс дээш насны охидод тохиолдох шээс дамжуулах замын хүндрэлгүй халдварын эмчилгээнд хэрэглэх шинэ эмийг зах зээлд гаргахыг зөвшөөрсөн ба уг халдварын эсрэг 30 жилийн дараа гарч буй шинэ эмчилгээ юм. Ойролцоогоор нийт эмэгтэйчүүдийн 50% нь амьдралынхаа турш дор хаяж нэг удаа шээсний замын халдвараар өвддөг бол, 30%-д нь халдвар дахидаг байна. Антибиотикт тэсвэржилт нэмэгдсэний улмаас стандарт антибиотикоор эмчлэхэд бэрхшээл учруулж байгаа нь шинэ эмчилгээний сонголтын хэрэгцээг бий болгосон.

Гепотидацин (Блюжепа-Blujera гэх худалдааны нэртэй) нь Триазааценафтилен гэх антибиотикийн шинэ ангилалд багтах анхны антибиотик ба нянгийн ДНХ-ийн репликацид оролцдог ДНХ гираз (топоизомераза II) болон топоизомераза IV ферментийг хориглодог. Энэ үйлдэл нь нянг тус антибиотикт тэсвэртэй болохыг бууруулж байгаа ба стандарт антибиотикт эмчлэгдэхгүй байгаа халдварыг эмчлэх сонголтыг бий болгож байна. Хамгийн түгээмэл тохиолдох гаж нөлөө нь суулгах, дотор муухайрах юм.

Мөн шинэ судалгаагаар заг хүйтэн өвчний халдварт үр нөлөөтэй байгаа талаар тогтоосон. Сүүлийн жилүүдэд заг хүйтэн өвчин үүсгэгч нян нь дэлхий даяар антибиотикт тэсвэржсэний улмаас тухайн өвчний эсрэг эмчилгээний үр дүн буурсаар байсан юм.

Эх сурвалж:

1. Gepotidacin: New antibiotic is effective against gonorrhea, could be first new treatment since 1990s, study says | CNN
2. FDA Green-Lights New Antibiotic for UTIs
3. Gepotidacin: a novel, oral, 'first-in-class' triazaacenaphthylene antibiotic for the treatment of uncomplicated urinary tract infections and urogenital gonorrhoea - PubMed

БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТ ДЭЛХИЙ ДАХИНД

Бичил биетний тэсвэржилт (ББТ) гэж бактер, вирус, мөөгөнцөр болон шимэгчид нь цаг хугацааны явцад өөрчлөгдөж, бичил биетний эсрэг эмэнд эмчлэгдэхгүй болохыг хэлэх ба энэ нь халдварыг эмчлэхэд төвөгтэй болгох болон өвчин тархах, өвчин хүндрэх, хөдөлмөрийн чадваргүй болох болон үхэлд хүргэх эрсдэлийг нэмэгдүүлдэг.¹

ББТ нь хүн болон малын эм, хөдөө аж ахуй, хүнс үйлдвэрлэл, байгаль орчны хамгаалал болон тогтвортой хөгжлийн ахиц дэвшлийг хэдэн арван жилээр ухраахаар заналхийлж байна. 2021 оны байдлаар дэлхий даяар ББТ 1.14 сая хүнийг үхэлд шууд хүргэсэн бол, 4.7 сая гаруй үхэлд холбоотой байсан.²

1 <https://www.who.int/health-topics/antimicrobial-resistance>

2 Naghavi, M., Vollset, S. E., Ikuta, K. S., Swetschinski, L. R., Gray, A. P., Wool, E. E., ... & Dekker, D. M. (2024). Global burden of bacterial antimicrobial resistance 1990–2021: a systematic analysis with forecasts to 2050. The Lancet, 404(10459), 1199-1226.



Иймд ББТ-ийн чиглэлээр хамтарсан яаралтай хариу арга хэмжээ авахгүй бол 10 жилийн дотор дэлхий нийтээр дундаж наслалтыг 1.8 жилээр бууруулж, 2050 он гэхэд 39 сая нас баралтын шалтгаан болж болзошгүй байна.³

Мөн ББТ-ийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийн хувьд дэлхий нийтийн эмчилгээний өртөг болон бүтээмжийн алдагдал 412 тэрбум ам.доллар болон 443 тэрбум ам.доллар⁴ мөн 2050 он гэхэд мал аж, ахуйн үйлдвэрлэлд ББТ улмаас дэлхийн ДНБ 575 тэрбум ам.долларын алдагдалд тус тус хүргэж болзошгүй.⁵

Эсрэгээрээ, халдварын урьдчилан сэргийлэлт болон хяналт, ус, эрүүл ахуй, ариун цэвэр, вакцинжуулалт, шинэ бичил биетний эсрэг эмүүд болон зохистой хэрэглээг идэвхжүүлж хамтран ажиллавал 2025-2050 оны хооронд 110 сая хүнийг үхлээс аварч 1 триллион америк долларын эдийн засгийн ашигтай байх боломжтой юм.⁶

Мөн, мал аж ахуйн салбар дахь бичил биетний эсрэг эмийн хэрэглээг 30% бууруулбал дэлхийн ДНБ-ийг 5 жилийн дотор 120 тэрбум америк ам.доллараар нэмэгдүүлэх болон⁷ хог хаягдал болон хаягдал усны менежмент, агаарын бохирдлын хяналт, болон зохистой бичил биетний эсрэг эмийн хэрэглээг нэмэгдүүлэх нь чухал байна.

ББТ нь хүний болон малын эрүүл мэндийн салбар дах бичил биетний эсрэг эмийн зохисгүй хэрэглээ, мал аж ахуй, далайн бүтээгдэхүүн, тариалан, байгаль орчинд гарч буй хаягдал /үүнд эмийн үйлдвэр, эмнэлэг, газар тариалан/-аас болж огцом нэмэгдэж байна. Стандартын бус хуурамч эм болон сул зохицуулалт нь уг асуудлыг улам дордуулж байгаа бөгөөд ялангуяа бага болон дунд орлоготой орнуудад энэ байдал илүү ажиглагддаг.⁸

3 [https://www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736\(24\)01867-1/fulltext](https://www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736(24)01867-1/fulltext)

4 GLG Report 2024: <https://www.amrleaders.org/resources/m/item/annex-to-the-glg-report>

5 Adamie, B. A., Akwar, H. T., Arroyo, M., Bayko, H., Hafner, M., Harrison, S., ... & Zakaria, S. (2024). Forecasting the fallout from AMR: Economic impacts of antimicrobial resistance in food-producing animals: <https://www.woah.org/app/uploads/2024/09/ecoamr-woah-animal-sector-web-reduced-23924.pdf>

6 Lewnard, J. A., Charani, E., Gleason, A., Hsu, L. Y., Khan, W. A., Karkey, A., ... & Laxminarayan, R. (2024). Burden of bacterial antimicrobial resistance in low-income and middle-income countries avertible by existing interventions: an evidence review and modelling analysis. The Lancet, 403(10442), 2439-2454.

7 Adamie, B. A., Akwar, H. T., Arroyo, M., Bayko, H., Hafner, M., Harrison, S., ... & Zakaria, S. (2024). Forecasting the fallout from AMR: Economic impacts of antimicrobial resistance in food-producing animals: <https://www.woah.org/app/uploads/2024/09/ecoamr-woah-animal-sector-web-reduced-23924.pdf>

8 OHHLEP One Health definition: <https://www.who.int/groups/one-health-high-level-expert-panel>



БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТИЙН ЭСРЭГ КОПЕНХАГЕНИЙН ТУНХАГЛАЛД МОНГОЛ УЛС НЭГДЛЭЭ.

З.Зузаан /ЭЗУ-ны магистр,
Нийгмийн удирдлагын магистр/

Дани улсын Копенхаген хотноо 2025 оны 9 дүгээр сард зохион байгуулагдсан ОУ-ын Эм Зүйн Холбооны 83 дахь конгрессийн үеэр ОУЭЗХ (FIP)-ны гишүүн 82 байгууллага **Копенгагенийн Тунхаглалд** гарын үсэг зурах арга хэмжээ зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд Монгол Улсыг төлөөлөн Эм зүйн мэргэжлээр төгсөгчдийн холбооны тэргүүн З.Зузаан оролцож гарын үсэг зурав.

Энэхүү тунхаглалаар бичил биетний тэсвэржилт (AMR)-ийн эсрэг улс орнууд хамтдаа тэмцэх тэргүүлэх чиглэлүүдийг тогтоож уриалга гаргахдаа:

- Олон улсын түншлэлийг дэмжих, бэхжүүлэх
- Вакцинжуулалтыг дэмжиж, бичил биетний эсрэг эмийг хариуцлагатай, зөв хэрэглэх
- Эмийн хангамж, нийлүүлэлтийн сүлжээг хамгаалж, бэхжүүлэх
- Бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээ болон эрүүл мэндийн үр нөлөөний талаарх судалгааны ажлуудыг шинэ шатанд гаргах зэрэг чухал асуудлуудыг хөндсөн.

Энэхүү үйл явдлын ач холбогдлыг онцгойлон тэмдэглэж ОУЭЗХ (FIP) нь оролцогч талуудыг багтаан видео (<https://youtu.be/B34QITDUKJc?si=cJBtdrDIZyK7dC5>) бүтээж баримтжуулсан.

Мөн бичил биетний тэсвэржилттэй холбоотой тохиолдлын судалгааг (https://www.fip.org/files/content/priority-areas/antimicrobial-resistance/FIP_2025_-_Legacy_Case_1.pdf) нэгтгэн гаргасан билээ.

Улс орнууд, гишүүн байгууллагууд 2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөгөө тус тунхаглалд тусгасан амлалттай уялдуулж байна.



The Declaration of Oviedo

Global Initiative on Drug Use Prevention

Б.Соёлчимэг ЭЭХХЗГ-ын
/Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн зохицуулалтын
асуудал хариуцсан мэргэжилтэн/

ОВИЕДОГИЙН ТУНХАГЛАЛ ЭМИЙН БОДЛОГОД МАНСУУРУУЛАХ БОДИСЫН ХЭРЭГЛЭЭНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНД ТУСГАХ АРВАН САНАЛ

ОРШИЛ

Мансууруулах бодисын хэрэглээ нь дэлхий хүн амд тодорхой сорилтуудыг дагуулсаар ирсэн. Сүүлийн арван жилийн дотор хар тамхины хэрэглээ 23% иар өссөн байна. Үүний зэрэгцээ хар тамхины хэрэглээтэй холбоотой асуудлуудын ихээхэн хэсгийг урьдчилан сэргийлэх боломжтойг шинжлэх ухаан нотолсон. НҮБ-ын Мансууруулах бодис, Гэмт хэрэгтэй тэмцэх газрын (UNODC) 2023 оны тайланд хар тамхины хэрэглээнээс урьдчилан сэргийлэх олон улсын томоохон хэмжээний санаачилгыг гаргаж хэрэгжүүлэх шаардлагатайг онцолсон.²

2023 оны 6-р сарын 9-ний өдөр Испанийн Овиедо хотод үндэсний болон олон улсын мэргэжилтнүүд олон улсын шинжлэх ухааны стандартад нийцүүлэн мансууруулах бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй стратегийг судлах зорилгоор Proyecto Hombre³ -аас зохион байгуулсан уулзалтад нийгэм, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг үр дагавар, донтох зан үйлтэй холбоотой эмзэг байдлыг шийдвэрлэх талаар зөвлөлдсөн. Хэлэлцүүлгийн үр дүнд хар тамхи, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх бодлогыг тэргүүлэх чиглэл болгон дараах тунхаглалыг батлав.

Улс орнуудад үйл ажиллагааны чиг болох дэлхийн тунхаглалд 2016 оны UNGASS-ийн үр дүнгийн баримт бичиг,⁴ 2019 оны Сайд нарын тунхаглал⁵-д нотлох баримтад суурилсан урьдчилан сэргийлэх ач холбогдлыг онцлон тэмдэглэж, НҮБ-ын ОУХБ/ДЭМБ-ын олон улсын стандартад мансууруулах бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх талаар дурдсан.⁶

НҮБ-н Мансууруулах эмийн комиссын саяхан гаргасан 65/4 “Шинжлэх ухааны иж бүрэн нотолгоонд суурилсан эрт урьдчилан сэргийлэх ажлыг дэмжих нь”⁷ тогтоолыг үндэслэн Овиедогийн тунхаглалыг дэмжигч байгууллагууд дараах арван саналаар тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх ахиц дэвшлийг түргэсгэхийн тулд эдгээр зорилгыг бататгаж, бүрэн хэрэгжүүлэхийг зорьж байна.

1. https://www.unodc.org/res/WDR-2023/WDR23_Exsum_fin_SP.pdf
2. https://www.unodc.org/res/WDR-2023/Special_Points_WDR2023_web_DP.pdf
3. <https://proyecto hombre.es/> <https://www.proyecto hombreastur.org/>
4. <https://www.unodc.org/documents/postungass2016/outcome/V1603301-E.pdf>
5. https://www.unodc.org/documents/hlr/19-06699_E_ebook.pdf
6. https://www.unodc.org/documents/prevention/UNODC-WHO_2018_prevention_stand-

dards_E.pdf

7. https://www.unodc.org/documents/commissions/CND/CND_Sessions/CND_66/ECN72023_CRP8_2303657E.pdf

САНАЛУУД

1. 2030 он гэхэд улс орнуудын эмийн эрэлтийг бууруулан стратеги, бодлогын хүрээнд төсвийнхөө 25%-аас доошгүй хувийг урьдчилан сэргийлэлтэд зориулахыг уриалж байна.

Бид урьдчилан сэргийлэлтийг үр дүнтэй, хэмнэлттэй бий болгохын тулд одоо байгаа нотолгоонд суурилан 2030 он гэхэд эмийн эрэлтийн бодлогын нийт төсвийн дөрөвний нэгийг эмийн хэт хэрэглээнээс урьдчилан сэргийлэхэд хуваарилж, тогтвортой байлгах үүрэг хүлээсэн үндэсний зөвшилцөлд хүрэхийг улс орнуудад уриалж байна. Энэхүү бодлого нь хүн бүрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хүний эрхийг хангах, мансууруулах эмийн эрэлт, хангамжийг бууруулах арга хэмжээг тэнцвэртэй байлгах явдал юм.

2. Бүх насныханд чиглэсэн урьдчилан сэргийлэх арга барилыг сурталчлах, эрт сэргийлэлтийг дэмжинэ.

Урьдчилан сэргийлэлтийг аль болох эрт эхлүүлж, жирэмслэлт, нярай, хүүхэд, өсвөр наснаас эхлэн гэр бүл, сургууль, олон нийтийн оролцооны тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, цаашид үргэлжлэх хугацааг тооцох шаардлагатай. Үр дүнтэй урьдчилан сэргийлэлт нь хүний амьдралын туршид хамгаалалтын хүчин зүйлсийг бэхжүүлэх, сэтгэл зүй, нийгмийн түвшинд чадавхжуулахад чиглэдэг.

3. Урьдчилан сэргийлэх боломжгүй эсвэл сөрөг хандлагаас зайлсхийхийн тулд судалгаа, үнэлгээг дэмжих.

Урьдчилан сэргийлэлт нь шинжлэх ухаан юм. Иймээс урьдчилан сэргийлэх бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэхдээ эрдэм шинжилгээний болон иргэний нийгмийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, олон улсын стандартад тулгуурласан нотолгоо, өгөгдөлд суурилсан хөндлөнгийн оролцоо, системчилсэн үнэлгээний механизмыг тусгах ёстой. Энэ арга нь буруу ойлголт, итгэл үнэмшилд суурилсан эмийн бодлогоос татгалзахад зайлшгүй шаардлагатай. Цаашилбал, нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын янз бүрийн нөхцөлд урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнтэй хэрэгжилтийг хангахад судалгаанд хөрөнгө оруулалт хийх нь маш чухал юм.

4. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх алсын харааг өргөжүүлж, эм хэрэглээнд хувь хүн болон нийгмийг анхаарал хандуулах.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь эмээс илүүтэй хувь хүнд анхаарлаа хандуулснаар хувь хүний түвшин, түүнийг тойрсон нийгмийн бүтэц, хууль эрх зүйн орчны хамгаалалтын үр нөлөөг харгалзан үздэг. Ингэснээр зөвхөн хууль бус эмийн хэрэглээнээс гадна тамхи, архи, каннабис, жороор олгодог эм, эсвэл тархалт ихтэй шинэ синтетик бодис зэрэг бүх төрлийн бодисын зүй бус хэрэглээнээс сэргийлдэг. Мөн бооцоот тоглоом, дижитал тоглоомын эмгэг зэрэг эмээс хамааралгүй донтолтоос урьдчилан сэргийлэх болно.

5. Эрсдэлтэй бүх иргэдэд урьдчилан сэргийлэлтийн гол уулзвар аргууд

Эм хэрэглээний нөлөө нь тэгш бус бөгөөд хүйс, үндэс угсаа, нас, бэлгийн чиг хандлага, газар нутгийн байршил, эрүүл мэнд, нийгмийн тодорхойлогч хүчин зүйлээс ихээхэн хамаардаг. Тиймээс урьдчилан сэргийлэх стратеги нь илүү тэгш, шударга бодлогыг бий болгох боломжийг олгохын тулд янз бүрийн эрсдэлийг арилгах цогц, огтлолцсон хандлагыг агуулсан байх ёстой. Урьдчилан сэргийлэх үйлчилгээ нь хараа



хяналтгүй насанд хүрээгүй хүүхдүүд, орон гэргүй хүмүүс, сэтгэцийн эмгэгтэй хүмүүс, шилжин суурьшсан болон дүрвэгсэд, уугуул иргэд болон бусад хүмүүс гэх мэт хамгийн гадуурхагдсан, доромжилсон бүлгийг хамрах, эрэмбэлэхийн тулд бүх хүчин чармайлтаа гаргах ёстой. Энэ нь тухайн нөхцөлд хувь хүн бүрийн онцлог хэрэгцээнд тохирсон урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах шаардлагатайг илтгэнэ.

6. Дэлхий даяар олон оролцогч талуудын урьдчилан сэргийлэлтийн тогтолцоог нэмэгдүүлж, үр ашиг, зардлыг баримтжуулах

Урьдчилан сэргийлэх тогтолцоо нь хүүхэд, залуучууд, хөгжлийн янз бүрийн насныханд өргөн цар хүрээтэй үйлчлэхийн тулд төрийн, төрийн бус, олон нийтийн олон салбарын олон талт арга хэмжээ, уялдаа холбоотой хүчин чармайлыг нэгтгэх ёстой. Улс орнууд олон улсын шинжлэх ухааны стандартад нийцүүлэхдээ үндэсний болон орон нутгийн түвшинд урьдчилан сэргийлэх боломжтой үйлчилгээг хүртэх ёстой. Тиймээс олон улсын түвшинд үр дүнтэй, зардал багатай гэдгээ баталсан урьдчилан сэргийлэх загваруудыг хуулбарлахад илүү их хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй.


7. Тасралтгүй тусламж үйлчилгээний хүрээнд бүх нийтийн хамрах хүрээг тэлэх
Нийгмийн эрүүл мэндийн хандлагын дагуу улс орнууд дэлхийн болон орон нутгийн хэмжээнд хүн бүрд хүртээмжтэй, эрүүл мэндийг дэмжих, эрт илрүүлэх, хөндлөнгөөс оролцох, хор хөнөөлийг бууруулах, донтолтыг эмчлэх, нөхөн сэргээх, нийгмийн хамгаалал, тасралтгүй тусламж үзүүлэхтэй уялдуулан хар тамхинаас урьдчилан сэргийлэх ажлыг хангах ёстой.

8. Бага, дунд орлоготой орнуудад зохих арга хэмжээг эрэмбэлэх
Бага, дунд орлоготой улс орнууд болон хүмүүнлэгийн хямралд өртөж буй бүс нутгуудад нийгэм, эрүүл мэндийн үндсэн дэд бүтэц дутагдаж болзошгүй. Энэ нөхцөлд урьдчилан сэргийлэхэд хөрөнгө оруулах нь нэн тэргүүний зорилт байх ёстой. Бид засгийн газар, олон улсын байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хооронд хүчтэй түншлэлийг бий болгох, түүнчлэн урьдчилан сэргийлэх туршлага солилцох, хор хөнөөл учруулахгүй байх хандлагад суурилсан урьдчилан сэргийлэх стратегийг нөхцөл байдалд нийцүүлэн нутагшуулахыг дэмжинэ. Мөн бид гэр бүл, бусад асран хамгаалагчид, залуучуудад хандсан, олон нийтэд түшиглэсэн удирдагчдыг чадавхжуулах санаачилгыг хэрэгжүүлэхийг дэмжинэ.

9. Одоогийн болон ирээдүй хойч үеийнхнийг урьдчилан сэргийлэлтэд мэргэшүүлэн чадавхжуулах

Урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхэд мэргэжлийн хүмүүсийн гол үүргийг хүлээн зөвшөөрч, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн ухааны хичээлийн үндсэн болон заавал орох сургалтын хөтөлбөрт эрсдэлтэй зан үйлээс урьдчилан сэргийлэх шинжлэх ухааныг тусгаж өгөхийг боловсролын салбарынханд уриалж байна. Урьдчилан сэргийлэлтэд дадлагажигчдыг тасралтгүй сургалтад хамруулж, гэрчилгээжүүлэх үйл явц, нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатайг бид онцолж байна.

10. Тандалт судалгаагаар урьдчилан сэргийлэх бодлогын төлөв байдалд хяналт тавих
Бид улс орнууд, Мансууруулах бодисын комисс, НҮБ-ын Мансууруулах бодис, Гэмт хэрэгтэй тэмцэх газар, ДЭМБ болон холбогдох байгууллагуудыг олон улсын, бүс нутаг, үндэсний болон орон нутгийн эмийн хяналт шинжилгээний тайлангийн тандалт, мэдээллийн тайлагналын систем эсвэл иргэний нийгэмтэй нягт хамтран ажиллах тусгай хяналтыг бий болгох замаар. хар тамхинаас урьдчилан сэргийлэх бодлогын хамрах хүрээ, хамаарал, хэрэгжилт, хөрөнгө оруулалт, үр нөлөөг зохих ёсоор үнэлэхийг урьж байна.



Хамтран ажиллах: Susana Al-Halabn, Eulalia Alemany, Alfonso Arana, Andrea Ascari, Graciela Barreto, Karen Biggs, Josй Mаrна Blanco, Jessica Bolacos, Doug Bond, Луна Bononato, Nicolas Bourguignon, Ilko Boyadzhiev, Michal Budniakiewicz, Pedro Caceda, Selva Careaga, Fabiон Chiosso, Ibe Christogonus, Ashley Colon, Nicolс Conde, Joe Coyte, Calixta De Balmaceda, Mari Paz De La Puente, Marta Del Arco, Cristina Delgado, Natacha Delmotte, Paulo Azevedo Dias, Covadonga Dnаz, Markйта Dolejsi, Alасana Drammeh, Cristian Duarte, Maria Angels Duch, Oriol Esculies*, Gonzalo Esquivel, Арбнзazu Fernбndez*, Josй Ramon Fernбndez-Hermida, Souraya Fremm, Orsolya Gancsos, Луча Goverна*, Alba Gonzбlez, Elisео Gonzбlez, Marta Gonzбlez, Yoana Granero, Sharif Hamid, Patrick Harvey, Amir Hasanovi□, Eider Hormaetxea, Jhonny Huanto, Martin Infante, Ruslan Isaev, Julio Cйsar Jonte, Phaedon Kaloterakis*, Habib Taigore Kamara, Rogers Kasirye*, Raffi Kaypekian, Kyoko Kondo, James Koryor, Matej Koir, Pablo Kurlander, Alex Lee, Domingo Legua, Paola Lami, Faisal Latif, Thomas Legl, Manuel Enrique Lypez, Marianella Lorenzo, Wadih Maalouf, Quetzalli Manzano, Regina Mattsson*, Gabriel Мејна, Orlando Менйндез, Guilherme de Sousa Meneses, Manuel Mingorance, Peter Moilanen, Jesъs Morбн, Gladness Hemedi Munuo, Sonja Phutachad Neef*, Danil Nikitin, Augusto Nogueira*, Irene Нъsez, George Ochieng Odalo, Jorge Olivares*, Carmen Orte, Nuria Parada, Belйн Pardo, Virginia Рйrez, Elena Presencio, Lidia Clara Rodriguez, Lucas Roncati, Patricia Ros, Miguel Rubio, Margarita Mаrна Sбnchez, Adriano Schuster, Luis Sdoia, Roberto Secades, Rosario Sendino, Dharav Shah, Elias Siboniyo, Ond□ej Sklenб□, Stig Erik Swhrheim, Eva Tenorio, Fabiон Tonda, Lohanis Ureca, Shane Varcoe, Elonsa Velarde, Olga Vicente, Cristina Von Sperling, Diana Vincent, Ina Vutkariov, Dandy Yela, Natalia Zachartzi*, Mikhail Zharkov.

*Ажлын хэсэг.

Туслах байгууллагуудын жагсаалтыг харна уу.
Тунхаглалд гарын үсэг зурна уу.
100 гаруй улсад төвлөрсөн цэгүүдтэй холбогдоно уу.
Тунхаглалыг 20 гаруй хэлээр татаж авах ажлын
хэсэгтэй холбогдоно уу.
www.oviedodeclaration.org



Ажиглагчид*: Испани (Эмийн үндэсний төлөвлөгөөний засгийн газрын төлөөлөгч, Эрүүл мэндийн яам) НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (урьдчилан сэргийлэх, эмчлэх, нөхөн сэргээх хэсэг) Европын зөвлөл (Помпиду групп) Балеарийн арлуудын их сургууль (Нийгэм, боловсролын сургалт, судалгааны бүлэг) Овьедогийн их сургууль (Донтуулах зан үйлийн судалгааны алба) Венийн Эмийн хороо ТББ * Ажиглагчид тунхаглалын агуулгатай санал нийлэхгүй байж болно.



UNODC

United Nations Office on Drugs and Crime

НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХАР ТАМХИТАЙ ТЭМЦЭХ АЛБА (UNODC)-ЫН 2025 ОНЫ ДЭЛХИЙН МАНСУУРАХ БОДИСЫН ТАЙЛАН:

Б.Соёлчимэг ЭЭХХЗГ-ын
/Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн зохицуулалтын
асуудал хариуцсан мэргэжилтэн/

Дэлхийн тогтворгүй байдал нь мансууруулах бодисын асуудлаас болж **нийгэм, эдийн засаг, аюулгүй байдлын зардал, эрсдэлийг улам нэмэгдүүлж байна.**

2025 оны 6 дугаар сарын 26-нд, Вена хот. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хар тамхитай тэмцэх алба (UNODC)-аас танилцуулсан **“Дэлхийн мансууруулах бодисын тайлан 2025”**-д тэмдэглэснээр, дэлхийн тогтворгүй байдлын шинэ үе нь мансууруулах бодисын асуудлыг шийдвэрлэхэд тулгарч буй сорилтыг улам гүнзгийрүүлж, зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийг хүчирхэгжүүлэн, мансууруулах бодисын хэрэглээг түүхэндээ байгаагүй өндөр түвшинд хүргэж байна.

UNODC-ийн гүйцэтгэх захирал Гада Уали хэлэхдээ “Дэлхийн мансууруулах бодисын тайлангийн энэ удаагийн хэвлэлд дурдсанаар мансууруулах бодисын хууль бус наймааны зохион байгуулалттай бүлэглэлүүд дэлхийн хямралуудыг ашиглан өөрчлөгдөж, эмзэг бүлгийн хүн амыг чиглэсээр байна” гэж онцолжээ. “Бид урьдчилан сэргийлэлтийг эрчимжүүлэх, хууль бус нийлүүлэлтийн сүлжээний бүх үе шатанд мансуурах бодисын наймааны уг үндэс шалтгааныг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн бид дэвшилтэт технологи ашиглаж хил дамнасан хамтын ажиллагааг бэхжүүлж, амьжиргааны өөр арга замыг дэмжих, нийлүүлэлтийн гол этгээдэд чиглэсэн шүүхийн арга хэмжээг авах замаар хариу арга хэмжээгээ сайжруулах хэрэгтэй байна. Нэгдсэн, уялдаа холбоотой бодлого хэрэгжүүлснээр бид гэмт бүлэглэлүүдийн сүлжээг задалж, дэлхийн аюулгүй байдлыг тогтвортой хадгалан, иргэд, олон нийтийг хамгаалж чадна.”

2023 онд 316 сая хүн (архи, тамхийг оруулаагүй) мансууруулах бодис хэрэглэсэн ба энэ нь 15–64 насны хүн амын 6 хувьтай тэнцэж байгаа бөгөөд 2013 онд энэ үзүүлэлт 5.2 хувь байсан. Каннабис нь 244 сая хэрэглэгчтэйгээр хамгийн өргөн хэрэглэгддэг мансууруулах бодисын тоонд хэвээр байна. Үүний дараа опиоидыг (61 сая), амфетамин (30.7 сая), кокаиныг (25 сая), ‘экстази’-г (21 сая) хүн хэрэглэсэн байна. Хүнд нөхцөл, тогтворгүй байдал болон зэвсэгт мөргөлдөөнөөс дүрвэн ирж буй шинэ эмзэг бүлгийн хүн амын нөлөөгөөр энэ тоо цаашид нэмэгдэх эрсдэлтэй байгааг тайланд анхааруулжээ.

Энэ тайланд мансууруулах бодисын хууль бус наймаа ба зохион байгуулалттай гэмт хэрэг, мансууруулах бодис хэрэглэгчийн болон тэдний гэр бүл, олон нийт, нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, мөн Европ дахь хүрээлэн буй орчинд мансууруулах бодисын үзүүлж буй нөлөөллийн талаар тусгай бүлгүүд багтсан байна.

Дэлхийд кокаины зах зээл өөрийн дээд амжилтыг шинэчилжээ

2023 онд кокаины үйлдвэрлэл, хураан авах ажиллагаа болон хэрэглээ бүгд урьд өмнө байгаагүй өндөр хэмжээнд хүрснээр кокаин нь дэлхийн хамгийн хурдтай тэлж буй хууль бус мансууруулах бодисын зах зээл болжээ. Хууль бус үйлдвэрлэл 3,708 тоннд хүрч, 2022 оныхоос 34 хувиар өссөн байна. Дэлхийн хэмжээнд кокаин хураан авсан хэмжээ

2,275 тоннд хүрч, 2019–2023 оны хооронд 68 хувиар өссөн нь дээд амжилт тогтоожээ. Нөгөөтгээгүүр, кокаины хэрэглээ 2013 онд 17 сая байсан бол 2023 онд 25 саяд хүрч өссөн байна.

Making the world safer from drugs, crime, corruption and terrorism

United Nations Office on Drugs and Crime | Vienna International Centre | PO Box 500 | 1400 Vienna | Austria
Tel.: (+43-1) 26060-0 | Fax: (+43-1) 26060-5866 | Email: unodc@unodc.org | www.unodc.org

Нэгэн цагт зөвхөн Латин Америкаар хязгаарлагдаж байсан кокаины хууль бус наймааны хэрцгий хүчирхийлэл, ширүүн өрсөлдөөн нь Баруун Балканы зохион байгуулалттай гэмт бүлгүүд зах зээл дэх нөлөөгөө нэмэгдүүлэхийн хэрээр одоо Баруун Европт хүртэл дэлгэрч байна.

Синтетик буюу нийлэг мансууруулах бодисын зах зээл тэлсээр байна

Үйл ажиллагааны өртөг багатай, илрүүлэх магадлал буурсан зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр синтетик буюу нийлэг мансууруулах бодисын зах зээл дэлхий даяар өргөжин тэлсээр байна. Энэ зах зээлд метамфетамин, амфетамин (үүнд ‘каптагон’ орно) зэрэг амфетамин төрлийн сэргээш (ATS) бодисууд давамгайлж байна. 2023 онд амфетамин төрлийн сэргээшүүдийн (ATS) хураан авсан хэмжээ түүхэндээ байгаагүй дээд түвшинд хүрч, дэлхий дахинд хураан авсан бүх синтетик бодисын тал хувийг эзэлжээ. Үүний дараа фентанил зэрэг нийлэг опиоидууд бичигдэж байна.

Сирид Асадын дэглэм нуран унаснаар ‘каптагон’-ы хууль бус наймааны ирээдүй тодорхойгүй болжээ. Улс төрийн шилжилтийн дараагаар тус улсад ‘каптагон’ үйлдвэрлэдэг томоохон үйлдвэрүүд илэрчээ. Эдгээр илрүүлэлт нь ‘каптагон’-ы нийлүүлэлтийг сааруулж болзошгүй ч 2024, 2025 оны хамгийн сүүлийн үеийн хураан авалтын мэдээллээс үзэхэд тус бодис нь голчлон Арабын хойгийн улс орнууд руу урссаар байгаа нь өмнө нь нөөцөлсөн их хэмжээний хадгаламжийг зах зээлд гаргаж буй эсвэл өөр газарт үйлдвэрлэлээ үргэлжлүүлж байж болзошгүйг харуулж байна.

Мансууруулах бодисын хууль бус наймаа асар их ашиг орлого авчирдаг

Тооцоолол харилцан адилгүй боловч хууль бус мансууруулах бодисын худалдаа жилдээ хэдэн зуун тэрбум ам.долларын орлого олдог. Гэмт бүлэглэлүүд үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх, мансууруулах бодисоо химийн аргаар нуух шинэ арга зам олох, харилцаагаа нууцлах болон түгээлтийг өргөжүүлэхийн тулд технологийг ашиглах зэрэг аргаар байнга шинэчлэл хийсээр байна.

Зохион байгуулалттай гэмт бүлгүүд тогтвортой мэт боловч таслан зогсоох боломжтой. Үүний тулд мансууруулах бодисын хууль бус наймааны бүлгүүдийн зорилго, удирдлага, бүтэц, үйл ажиллагааны арга барилыг сайтар судлах шаардлагатай. Гэмт бүлгүүдийн сүлжээг зураглах нь тэдний эмзэг цэг, гол оролцогчид, тэдэнд дэмжлэг үзүүлэгчид болон оролцох боломжтой онцгой цэгүүдийг тодорхойлоход тусална. Мөн хууль сахиулах байгууллагууд мансууруулах бодисын нийлүүлэлтийн сүлжээнд ашиглагдаж буй өндөр түвшний хэрэгслийн нарийвчлалд нийцэхүйц технологи болон ур чадварын сургалтад хөрөнгө оруулах талаар авч үзэх нь зүйтэй.

Мансууруулах бодисын хэрэглээний үр дагавар

Мансууруулах бодисын хэрэглээтэй холбоотой эмгэгүүд нь хувь хүн, орон нутаг болон эрүүл мэндийн тогтолцоонд аль хэдийнээ ихээхэн дарамт учруулж байгаа бөгөөд олон талт хамтын ажиллагаанаас ухрах хандлага болон нөөцийг өөр чиглэлд хуваарилах үйл явц нь энэ асуудлыг улам хүндрүүлэх эрсдэлтэй байгааг тайлан онцолжээ.



Мансууруулах бодисын хэрэглээтэй холбоотой эмгэгийг шийдвэрлэж чадахгүй байх өртөг асар өндөр бөгөөд зөвхөн 2021 онд гэхэд бараг хагас сая хүн нас барж, хөдөлмөрийн чадвар алдалт болон эрт нас баралтаас шалтгаалан 28 сая эрүүл амьдралын жил (DALY) алдагджээ. 2023 онд ийм эмгэгтэй хүмүүсийн 12 хүн тутмын зөвхөн нэг нь ямар нэг хэлбэрийн эмчилгээ авсан гэж тооцоолжээ. Нотолгоонд тулгуурласан эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх нь мансууруулах бодисын хэрэглээнээс хүн болон нийгэмд үзүүлэх эрүүл мэндийн сөрөг нөлөөг бууруулахад чухал ач холбогдолтой гэж тайланд дурджээ.

Мансууруулах бодисын хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө

Тайланд тэмдэглэснээр мансууруулах бодисын хэрэглээ, тариалалт ба хууль бус наймаа, түүнчлэн энэ хууль бус эдийн засгийг хязгаарлах зорилгоор хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ хүртэл Европын хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж байна. Мансууруулах бодисын тариалалт, үйлдвэрлэл нь ой устгал, газрын ашиглалтын өөрчлөлт, агаар, хөрс, усны бохирдол зэрэг үр дагаврыг үүсгэх боломжтой бөгөөд энэ нь орон нутгийн түвшинд ноцтой хэмжээнд хүрч болзошгүйг тайланд онцолжээ.

Европт 2013–2023 оны хооронд мансууруулах бодисыг нууцаар үйлдвэрлэдэг лабораториудыг илрүүлэн устгасан тоо нэмэгджээ. Ийм үйлдвэрлэл их хэмжээний хаягдал үүсгэж, цэвэрлэгээ болон экосистемийг сэргээхэд ихээхэн зардал гаргах эрсдэлтэй. Гэсэн хэдий ч тайланд дурдсанаар мансууруулах бодисын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явцад хүрээлэн буй орчинд учрах хор хөнөөлийг тэргүүлэх асуудал болгон авч үздэггүй бөгөөд ихэнх хаягдал болон байгаль орчинд учирсан бусад нөлөөлөл нь бүртгэгддэггүй байна.

* * * * *

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаар холбогдон авна уу:

Sonya Yee Chief,

UNODC Advocacy Section

Mobile: (+43-699) 1459-4990

Email: [unodc-press\[at\]un.org](mailto:unodc-press[at]un.org)

* * * * *



МАНАЙ БАЙГУУЛЛАГА НЬ МОНГОЛ УЛСЫН ЭМИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН УЛСЫН ЖИШИГ ТОГТООХ ҮНЭЛГЭЭ (GLOBAL BENCHMARKING TOOL)-ЭЭР ТӨЛӨВШЛИЙН ТҮВШИН 3 (MATURITY LEVEL 3)-Т ХҮРГЭХИЙГ ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛГО БОЛГОН АЖИЛЛАЖ БАЙНА.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага нь 2018 оноос улс орнуудын эм, вакцины зохицуулалтын байгууллагуудыг Олон улсын жишиг тогтоох үнэлгээний аргачлал (Global benchmarking tool)-ийн дагуу үнэлж 1-ээс 4 хүртэлх шатлал бүхий “төлөвшлийн түвшин” гэх олон улсын жишиг ойлголтыг гаргаж ирсэн. Энэхүү үнэлгээний аргачлал нь улс, орнуудад эм, вакцины зохицуулалтын үйл ажиллагааны чадавхаа бодитоор үнэлж, сайжруулахад тусалдаг. Улс орнууд Төлөвшлийн түвшин 3 болон 4-т хүрснээр ДЭМБ-ын жагсаалтад орсон эрх бүхий байгууллага (WHO-Listed Authority буюу WLA)-ын үнэлгээнд хамрагдах боломжтой болно. Энэхүү WLA жагсаалтад орох үнэлгээг ДЭМБ 2021 оноос эхлүүлсэн бөгөөд 2024 оны 5 дугаар сарын байдлаар 33 улс эм эсвэл вакцины зохицуулалтаараа тус жагсаалтад орсон. Манай улсын Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар нь 2022 онд ДЭМБ-ын дэмжлэг дор Олон улсын жишиг тогтоох үнэлгээний аргачлалаар өөрийн үнэлгээг хийсэн бөгөөд 2023 оноос 2026 онд хэрэгжүүлэх “Байгууллагын хөгжлийн төлөвлөгөө”-г боловсруулан баталж, тасралтгүй хэрэгжүүлэн 2027 онд Төлөвшлийн түвшин 3 – т хүрч тогтвортой, нэгдмэл үйл ажиллагаа бүхий зохицуулалтын системийг бий болгохоор ажиллаж байна.



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БЭХЖҮҮЛЭХ 3 ЖИЛИЙН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА.

БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-ын групп сургалтын хөтөлбөрийн хүрээнд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 45 албан хаагч 2025-2027 онд “Монгол Улсад эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын чадавхыг бэхжүүлэх нь” сэдэвт сургалтад хамрагдахаар болсон билээ.



Энэхүү хөтөлбөрийн 2025 оны сургалтын хүрээнд тус газрын 14 албан хаагч 08 дугаар сарын 24-нөөс 09 дүгээр сарын 06-ны өдрүүдэд БНСУ-д “Эмийн бүртгэл”, “Чанарын удирдлага ба Эмийн үйлдвэрийн зохистой дадлын стандартууд”, “Эмийн зохицуулалтын шинжлэх ухаан”, “Эмийн эмнэлзүйн туршилт судалгааны загвар ба ёс зүйн асуудлууд”, “Эмийн гаж нөлөөний мэдээлэл болон менежмент”, “Эмнэлгийн хэрэгслийн ангилал ба бүртгэлийн тогтолцоо” зэрэг сэдвүүдээр сургалтад хамрагдав.

Уг төсөл хөтөлбөрийн хүрээнд КОЙКА болон КОЙКА-гийн сургалт төгсөгчдийн холбоотой хамтран 2025 оны 10 сарын 22-ны өдөр салбарын мэргэжилтнүүд болон олон нийтэд зориулж Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга Т.Мөнхтуул, Эмийн аюулгүй байдлын тандалт судалгааны газрын ахлах мэргэжилтэн Л.Дулмаа, мэргэжилтэн У.Соёл-Эрдэнэ нар “Эмийн бүртгэл”, “Эмийн аюулгүй байдал, фармаковижиланс”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, эмийн цахим жор” сэдвүүдээр сургалт явуулж, БНСУ-ын эмийн зохицуулалтын талаарх зарим туршлагаас хуваалцсан ба сургалтад 170 гаруй хүн хамрагдлаа.



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Засгийн газрын 2024 оны 10 дугаар
сарын 02-ны өдрийн 109 дүгээр
тогтоолын хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛ ЭРХЭЛДЭГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Албан хаагч, албан тушаалтны
ёс зүйн хэм хэмжээ

2.1.Ард түмэндээ чин сэтгэлээсээ үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хүрээнд дараах хэм хэмжээг мөрдөнө:

2.1.1.хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэх;

2.1.2.хүн, хуулийн этгээдийн асуудлыг хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэж хариу өгөх;

2.1.3.хүн, хуулийн этгээдээс хууль тогтоомжид заагаагүй нэмэлт баримт бичиг, төрийн цахим мэдээллийн санд байгаа, эсхүл төрийн байгууллага хоорондоо цахим хэлбэрээр солилцон ашиглах боломжтой баримт бичгийг цаасан хэлбэрээр шаардахгүй байх;

2.1.4.ажлын байр, олон нийтийн газар, цахим орчин болон нийгмийн сүлжээнд төрийн албаны нэр хүндэд харшлах үйл ажиллагаанд оролцохгүй, үг, үйлдэл гаргахгүй байх;

2.1.5.хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичиг, төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, түүний хэрэгжилтийн талаарх эх сурвалжгүй, үндэслэлгүй мэдээ, мэдээлэл хийх, тараахгүй байх.

**“ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙГ ҮЛ ТЭВЧИХ
СЭТГЭЛГЭЭГ ХЭВШҮҮЛЬЕ”**



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Засгийн газрын 2024 оны 10 дугаар
сарын 02-ны өдрийн 109 дүгээр
тогтоолын хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛ ЭРХЭЛДЭГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Албан хаагч, албан тушаалтны
ёс зүйн хэм хэмжээ

2.2.Зан харилцаа, үг, үйлдлээрээ хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хүрээнд дараах хэм хэмжээг мөрдөнө:

2.2.1.ажлын байр, олон нийтийн газар, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа болон цахим орчин, нийгмийн сүлжээнд зүй бус үг хэрэглэхгүй, үйлдэл, зан байдал гаргахгүй байх;

2.2.2.үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэхдээ хүний эрх болон хүн, хуулийн этгээдийн нэр төрийг хүндэтгэх, тэдэнд учирч болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьчилан сэргийлэх;

2.2.3.албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн хүний хувийн болон эмзэг мэдээллийг хадгалах, хамгаалах.


2.3.Хууль ёс, шударга ёсыг дээдлэн сахих, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хүрээнд дараах хэм хэмжээг мөрдөнө:

2.3.1.Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг биелүүлэх;

2.3.2.Төрийн болон албаны нууцын тухай хуулиар хамгаалагдсан нууцыг хадгалах, хамгаалах;

2.3.3.өргөсөн тангарагтаа үнэнч байж, эх орон, ард түмнийхээ эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос үргэлж дээгүүр тавих;

**“ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙГ ҮЛ ТЭВЧИХ
СЭТГЭЛГЭЭГ ХЭВШҮҮЛЬЕ”**





ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Засгийн газрын 2024 оны 10 дугаар
сарын 02-ны өдрийн 109 дүгээр
тогтоолын хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛ ЭРХЭЛДЭГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Албан хаагч, албан тушаалтны
ёс зүйн хэм хэмжээ

2.3.4.албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдлаас татгалзах, хамаарал бүхий этгээдийн ашиг сонирхолтой холбогдох аливаа шийдвэр гаргахгүй байх;

2.3.5.албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхол нь хөндөгдөх хүн, хуулийн этгээдэд хууль бусаар давуу байдал олгохгүй байх, тэднээс бэлэг, хөнгөлөлттэй зээл, үйлчилгээ, бусад хангамж, ашигтай нөхцөл бүхий саналыг хүлээж авахгүй байх;

2.3.6.хууль тогтоомж зөрчсөн, авлига авсан, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн үйлдлийн талаарх мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдээлэх;

2.3.7.өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээл, түүнд орсон өөрчлөлтийг тухай бүр үнэн зөв мэдүүлэх;

2.3.8.төрийн байгууллага, албан тушаалын болон албан тушаалтны нэрийг өөрт ашигтай байдал бий болгох зорилгоор ашиглахгүй байх;

2.3.9.албан хаагчийг ажил үүргээ гүйцэтгэхэд хууль бусаар нөлөөлөх, саад учруулах, хөндлөнгөөс оролцох, хууль бус үйлдэл, эс үйлдэхүй хийхийг шаардахгүй байх;

2.3.10.төрийн байгууллагын эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмж болон албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй байх;

**“ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙГ ҮЛ ТЭВЧИХ
СЭТГЭЛГЭЭГ ХЭВШҮҮЛЬЕ”**

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ХЭЛТЭС

1. Эрүүл мэндийн салбарт гардаг нийтлэг зөрчил

Иргэдийн хувьд эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хууль тогтоомжоор зөвшөөрсөн болон даатгалын байгууллагатай байгуулсан гэрээнд зааснаас бусад төлбөр, нэмэлт төлбөр авдаг, үйлчлүүлэгч иргэнээр эм, тариа, эмнэлгийн хэрэгслийн төлбөрийг гаргуулдаг, зайлшгүй шаардлагын улмаас уг төлбөрийг гаргуулсан тохиолдолд төлбөрийг буцаан олгодоггүй, төлбөрийг эмчлэгч эмчээс гаргуулахаар шаарддаг, тухайн эмнэлгээс үзүүлэх боломжтой тусламж, үйлчилгээг үзүүлэхгүй бусад эрүүл мэндийг байгууллага руу явуулдаг зэрэг зөрчил түгээмэл тохиолддог.

Мөн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас даатгалын санхүүжилтээр үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний мэдээллийг иргэнд хүргэх, чанартай тусламж үйлчилгээ авсан эсэхийг нягтлах зорилгоор үйлчилгээ авсан иргэдийн тодорхой хувьд мессеж илгээх (SMS үйлчилгээ) үйлчилгээг нэвтрүүлсэн нь зохих үр дүнд хүрч байгаа боловч иргэн бүрд очиж, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан эсэх, чанартай үйлчилгээ авсан эсэхийг хянах боломжгүй байгаа юм.

Иймд Авлигатай тэмцэх газраас 2022 оны 11 сард Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай хамтран “Эрүүл мэндийн даатгал-Иргэний хяналт-Тусламж үйлчилгээ” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан. **Энэ дагуу нэгдсэн зөвлөмжийг гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх,** тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хүндрэл бэрхшээлийг арилгах чиглэлд анхаарч ажиллах шийдэлд хүрсэн юм.


Хэлэлцүүлгийн гол үр дүн нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан иргэн авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэлд цахим байдлаар хяналт тавих эрхийг И-Монголиа цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх боломжтой гэсэн дүгнэлтэд хүрч, цаашид бодит ажил хэрэг болоход оролцогч талууд хамтран ажиллахаар болсон бөгөөд Авлигатай тэмцэх газраас Эрүүл мэндийн сайдад хэлэлцүүлгийн оролцогчдоос гарсан зөвлөмжийг хүргүүлжээ. Улмаар зөвлөмжийн дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, И-Монголиа академитай хамтран “И-Монголиа” системд иргэн авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээгээ хянах үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Энэхүү үйлчилгээ нэвтэрснээр иргэн бүр “И-Монголиа” системд нэвтрэн дээр дурдсан үйлчилгээ авсан эсэх, үйлчилгээний үнэ төлбөрийг мэдэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт санал бөгөх, тусламж үйлчилгээ авах үед гарсан зөрчил дутагдлын талаар мэдээлэх боломж бүрдэх сайн талтай юм.

2. Авлигын гэмт хэргийг бууруулахад иргэд маш том үүрэг оролцоотой.

Авлигажсан оронд жирийн иргэд эдлэх ёстой эрхээ мөнгөөр худалдаж авдаг гэх үг бий. Ингэж л тэд бидний гоё хотод амьдрах, гэр оронтой болох боломжийг хулгайлдаг. Иймээс л авлигатай бүх шатандаа тэмцэхийн тулд “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан юм. Харин үүнийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо ус агаар мэт чухал.

Тэгээд бид яаж тэмцэх юм бэ? гэж бодож байж магадгүй. Тэгвэл танд одоо тайлбарлаад өгье өө. Төрийн үйлчилгээг авах нь хүнд суртал ихтэй байгаа бол та АТГ-ын 110 утсанд гомдол гаргаж болно. Учир нь хүнд суртал гэдэг нь авлига авах нөхцөлийг



бүрдүүлдэг гэж үздэг. Хэрэв танай хүүхэд харьяаллын сургууль цэцэрлэгтэй хамрагдаж чадахгүй байгаа бол мөн л гомдол мэдээллээ холбогдох газруудад гаргах боломжтой. Ер нь авлигын асуудлыг “за яршиг өө” гээд тоохгүй өнгөрөх асуудал огтоос биш юм. Таны бүтээлцсэн нийгэмд үр хүүхэд тань үргэлжлүүлэн амьдарна. Дутагдлыг хэлдэг, шүүмжилдэг иргэн та улс орноо авлигаас ангижруулахад гол хүч нь.

3. Авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хэрхэн өгөх вэ?

Бат хамт ажилладаг хүнээ авлига авсныг олж мэджээ. Тэр холбогдох байгууллагад мэдүүлэх үү байх уу гэж баахан эргэлзэж гэнэ. “Ер нь л мэдэгдсэн нь дээр байх. Илэрвэл баларсан юм болно” гэж бодох боловч нөгөө талд түүний амьдралыг дэндүү сайн мэдэхийн хувьд бас төөрч орхилоо. Өртэй, зээлтэй, олон хүүхэдтэй, ганцаараа ажил хийдэг. За эхний удаа байна өөрт хамаагүй асуудлыг дуугүй өнгөрье. Харин дахин ийм асуудал гарвал шууд л мэдэгдэнэ гэж шийджээ.

Гэтэл удалгүй авлига авсан нь илчлэгдэж. Бат “Авлигын талаар мэдээлэх үүрэг”-ээ биелүүлээгүй тулд гурван сар цалингийн 30 хувьдуулжээ.

Авлигыг мэдээлэх нь сонголт биш таны үүрэг. Тиймээс та авлигын талаар баттай нотолгоотой мэдээлтэй байгаа бол Авлигатай тэмцэх газарт нэрээ нууцлан мэдээлэл өгөх боломжтой.

Ингэхдээ бичгээр, биечлэн, 110 тусгай дугаарын утсаар, цахимаар, шуудангаар, E-mongolia цахим системээр мэдээлэл өгөх боломжтой. Нууцыг чандлан хадгалдаг.

4. Хясан боогдуулах гэж юу вэ?

Энэ дугаараар “Хясан боогдуулах” гэдэг үг ямар утгатай болох, ямар тохиолдлыг хясан боогдуулсан гэж үзэх шалтгаан болдог талаарх мэдээллийг хүргэе.

Хясан боогдуулсан үйлдэл гэдэг нь тухайн иргэн, ААН үйлчилгээ авахад шаардлагатай бүх шаардлагыг хангасан байхад үйлчилгээг нь үзүүлэхгүй, зээл, тусгай зөвшөөрлийг нь өгөхгүйгээр дахин, дахин тодорхой бус зүйл, шаардлагыг тавихыг хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл бүх шаардлагыг хангасан байхад л ямар ч тодорхой биш үйлдлийг шаарддаг. Хэрэв ийм аргагүй нөхцөл байдалд орж хээл хахууль өгснөө хууль хяналтын байгууллагад сайн дураараа илчилбэл тухайн хүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж, эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг хуультай.

Үүнийг бодит жишээгээр тайлбарлая. Хүнсний худалдаа, борлуулалтын тусгай зөвшөөрөлтэй “Б” компани БНХАУ-аас Замын-Үүдийн боомтоор түргэн муудах хүнсний бараа бүтээгдэхүүнийг Монгол Улс руу оруулж ирэх шаардлагатай болжээ. Гэтэл хилийн Мэргэжлийн хяналтын Улсын байцаагч Х нь их хэмжээний хахууль нэхжээ. Иймээс Б компани шүүхэд гомдол гаргасан. Шүүхээс тус үйлдлийг хясан боогдуулсан гэж үзжээ. Учир нь, “Б” компанийн оруулж ирж байгаа хүнсний бүтээгдэхүүн нь түргэн муудах, онцлог чанартай бараа, бүтээгдэхүүн байсан учраас тус компани нь их хэмжээний хохирол хүлээхгүйн тулд төрийн албан хаагчийн тавьсан хууль бус саналыг хүлээн авахаас өөр сонголт байгаагүй гэж үзсэн байна.





